MMINFO.

19 дэх жилдээ

МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,129.778... ҮСХ-ны өгөгдлийн мэдээгээр

2017.02.02. Пүрэв. №022 (4636) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

П.СЭРГЭЛЭН: ХОРШООНЫ ХӨГЖЛИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГООР ДЭМЖИНЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖИЛД СЭТГЭЛ ОЮУНАА ЗОРИУЛАХ АН-ЫН БҮСГҮЙЧҮҮД

V нүүрт

ЧУХАЛ ХҮН

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Д.МЯГМАРСҮРЭН: ТЕАТР НАМАЙГ ХҮМҮҮЖҮҮЛЖ, ХАРИУЦЛАГАД СУРГАСАН

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс

ҮЗЭЛ БОДОЛ

НАМ, АЛБАН ТУШААЛД ӨГДӨГ МӨНГӨНӨӨСӨӨ ЭХ ОРОНДОО ХАНДИВЛАНА УУ

Ч.ЧУЛУУН

Дэлхийд нүүрлэсэн эдийн засгийн хямралын сүүдэр биднийг дайрахуйд импортын бараа бүтээгдэхүүнээс бүрэн хамааралтай, уул уурхайгаас өөр экспортгүй жижиг улс чинь тэр дороо л өвдөг сөхөрдөг юм байна. Банкныхаа зээлийг арайхийж давдаг байсан иргэд эдүгээ гудамжны өнцөгт орших хүнсний жижиг мухлагтаа өр тавиад багагүй хугацаа өнгөрчээ. Удахгүй цагаан сар болно. Өртэй гээд хоосон сууж байхгүй л байх. Өр зээлээ нэг гараараа төлөөд дахин нөгөө гараараа зээл, өр тавиад ч болов шинэлэх биз. Өмнө нь эцэг, эхдээ боломжоороо нэмэр болж, ууцыг нь ч болов худалдаж аваад өгчихдөг байсан юм. Энэ жил ч сарвайгаад зогсох 20 мянган төгрөгөө авч үлдэж чадаж байвал их юм болох нь шиг байна. Ийм бодол хөврөхүйд иргэд төдийгүй хөрөнгө бэлтэй хүмүүс Засгийн газартаа хандив өгч байгаа сураг чих дэлсч, цахим ертөнцөөр хэн хэчнээн төгрөг хандивласан тухай мэдээлэл гарч эхэллээ.

Үргэлжлэл нь III нүүрт

Дугаарын 60 мөр

НӨАТ-ын баримтаа шалгаж аваарай

Б.СУМЪЯА

НӨАТ-ын хууль өнгөрсөн оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэлснээс хойш иргэд аливаа худалдан авалт хийсэн баримтынхаа дугаар, үнийн дүнг бүртгүүлэн урамшуулалт сугалаанд оролцож, хоёр хувийн буцаалтаа эргүүлэн авах болсон. Нэг талаар иргэнд, нөгөө талаар зарим аж ахуй нэгжийг татвараас зугтаах байдлыг хумисан нь улсын төсөвт эерэг нөлөө үзүүлж эхэлсэн жишээ олон байна. Гэхдээ нэг асуудал байна. Иргэд, худалдан авагчдаа дэлгүүр, супермаркетаас худалдан авалт хийснийхээ дараа баримтаа сайн шалгаж аваарай. Иргэн таны бүртгүүлсэн баримт дотроос "Үнийн дүн зөрүүтэй" гэх баримт гарч ирэх вий. Зарим хүний хувьд ийм баримт гараагүй байж болох хэдий ч, ийм тохиолдол нэлээдгүй гарч буйг албаныхан ч хэлж байсан юм.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР





ДЭЛХИЙ

ФИЛИППИН ДЭХ АЛЛАГА

Б.ДАВААХҮҮ

Филиппиний өнгөрөгч оны Ерөнхийлөгчийн сонгуульд "шийтгэгч" хочит Родриго Дутерт ялалт байгуулсан. Өмнө нь гэмт хэрэг зөрчлөөрөө улсдаа толгой цохиж явсан Давао хотын захирагчаар ажиллаж байсан тэрбээр гэмт хэрэгтнүүдтэй хатуу гараар тэмцсэний дүнд дээрх хочийг авсан хэрэг. Улмаар улсын Ерөнхийлөгчийн албан тушаалд томилогдсоныхоо дараа Родриго Дутерт хар тамхины эсрэг дайн эхлүүлсэн. Энэ хүрээнд гэмт хэрэгтэн эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд буудах эрхийг цагдаагийнханд өгч, цаазыг ялыг ч сэргээсэн нь тухайн үедээ л дэлхийн хэвлэлийн анхаарлыг татаж байсан удаатай. Тэгвэл олон улсын хүний эрхийн байгууллагын "Эмнести интернэшнл" байгууллага Филиппиний цагдаа нар хар тамхины эсрэг дайны нэрийн дор "нарийн төлөвлөсөн" хууль бус аллага үйлдэж буйг мэдээлэв. Мөн тайландаа тус аллага хүн төрөлхтөний эсрэг гэмт хэрэгт ч тооцогдох боломжтойг дурьджээ. Ерөнхийдөө өнгөрсөн оны долдугаар сард Р.Дутерт Ерөнхийлөгч болсноос хойш хар тамхины эсрэг дайны галын шугамд 7000 гаруй хүний амь үрэгдсэн байх юм. Гэвч улсын Ерөнхийлөгч нь тухайн гэмт хэргийн сэжигтэн эсэргүүцэл үзүүлсэн тохиолдолд цагдаа нар галнээх эрхтэй гэх ганц үгээр аллагын хэргээ өмгөөлсөөр байдаг аж. Харин энэ долоо хоногт тэр бодлогодоо эргэлт хийсэн. Учир нь цагдаагийнхан мөн л хар тамхины эсрэг дайн нэрийн дор БНСУ-ын нэгэн бизнесмэнийг хөнөөснөөр Ерөнхийлөгч эр ч цагдаагийнханд олгосон гэмт хэргийн сэжигтэн рүү гал нээх давуу эрхээ эргэх харахаар болжээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

БАЙНГЫН ХОРОО

Д.ОЮУНХОРОЛ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛНЭ

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Аялал, жуучлалын салбарын өнөөгийн байдал болон эдийн засгийг сэргээх хөтөлбөрт аялал, жуучлалын талаар тусгагдсан зорилт, аргахэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц, тулгамдсан асуудлуудын талаархи Байгаль орчин, аялал жуучлалын сайдын мэдээллийг сонссон юм.

Үргэлжлэл нь II нүүрт

ХААН банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2460.00	2479.00	ФУНТ	3040.00	3151.00
ЕВРО	2623.00	2699.00	РУБЛЬ	39.20	42.70
ИЕН	21.53	22.09	ЮАНЬ	358.00	362.40

Худалдаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2467.00	2480.00	ФУНТ	3069.00	3175.00
ЕВРО	2632.00	2726.00	РУБЛЬ	39.82	43.52
ИЕН	21.58	22.37	ЮАНЬ	359.00	364.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

Д.ОЮУНХОРОЛ: АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ ШИНЭЧИЛНЭ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Салбарын яамнаас аялал жуулчлалын эрх зүйн орчныг шинэчлэх, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, аяллын төрлийг нэмэгдүүлэх, жуулчид хүлээн авах хүчин чадлыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, улмаар аялал жуулчлалын салбараас эдийн засгаас оруулах үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг олон зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлон ажиллаж байгааг Байгаль орчин, аялал жуучлалын сайд Д.Оюунхорол танилцуулгынхаа эхэнд онцоллоо. 2016 онд Монгол Улсад 404 мянган жуулчин аялаж, аялал жуулчлалын салбараас дотоодын эдийн засагт 321 сая ам.долларын орлого оруулжээ. Энэхүү тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад, 2012 оноос хойш анх удаа гадаадын жуулчдын тоо 4.4 хувиар, салбарын орлого 11.4 хувиар тус тус өссөн байна.

Дэлхийн аялал жуулчлалын консулаас гаргасан аялал жуулчлалын эдийн засгийн үр нөлөө статистик мэдээллээс харахад, 2015 онд Монгол Улсын аялал жуулчлалын салбар ДНБ-ий 5.3 хувийг бүрдүүлсэн бөгөөд салбарын хөрөнгө оруулалтын мэдээ 1.2 их наяд төгрөг байсан нь нийт хөрөнгө оруулалтын 21.9 хувийг эзэлсэн аж. Манай улсыг зорин ирсэн жуулчдын иргэний харьяаллаас үзэхэд, нийт жуулчдын 38 хувийг БНХАУ, 18 хувийг ОХУ, 12 хувийг БНСУ, таван хувийг

> ...Манай улсыг зорин ирсэн жуулчдын иргэний харьяаллаас үзэхэд, нийт жуулчдын 38 хувийг БНХАУ, 18 хувийг ОХУ, 12 хувийг БНСУ, таван хувийг Япон Улсын иргэд эзэлж байгаа юм байна. Түүнчлэн Америк, Герман, Казахстан, Австрали улсын иргэд тус бүр 2-4 хувийг эзэлдж байгаа аж...

Япон Улсын иргэд эзэлж байгаа юм байна. Түүнчлэн Америк, Герман, Казахстан, Австрали улсын иргэд тус бүр 2-4 хувийг эзэлдж байгаа аж. Харин Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекст оролцсон нийт 141 орноос Монгол Улс 99 дүгээрт эрэмбэлэгдсэн байна. 2016 оны байдлаар дотоодод 274 аялал жуулчлалын компани, 473 зочид буудал, 385 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нийт ажлын байрны 4.3 хувь нь тус салбарт байгаа аж. Байгаль орчин, аялал жуучлалын сайд аялал жуулчлалын улирлын хамаарлыгбууруулах,дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр салбарын яамнаас хийж буй ажлууд, зорилт болон хууль эрх зүйн орчны талаар мэдээллээ. Аялал жуулчлалын тухай хууль 2000 онд батлагдсан байна. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд тус яамнаас Казиногийн тухай хуулийн төслийг боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нь хэлэлцүүлгийн шатанд байгаа юм. Мөн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хурдан морины бооцоот уралдааны тухай хуулийн төслүүдийг боловсруулж байгаа талаар дурдав. Үргэлжлүүлэн тэрбээр тулгамдсан асуудлуудыг дэлгэрэнгүй танилцуулсан юм. Танилцуулгатай холбогдуулан УИХ-ын гишүүд зарим зүйлийг асууж, тодруулсан юм.

> "ОУВС–тай гэрээ хийж байхад Хөгжлийн банкны хуулийг батлах нь буруу"

Мөн хуралдаанаар УИХ-ын гишүүн Б.Жавхлан нарын 19 гишүүн өргөн мэдүүлсэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлэг хийлээ. Хэлэлцүүлгийн шатанд гишүүд Олон улсын валютын сангийн /ОУВС/ төлөөлөгчид Монгол Улсад ирчихсэн, "Стэнд бай" хөтөлбөрийголгохэсэхасуудлаа Засгийн газрын гишүүдтэй ярилцаж эхэлж байгаа. Гэтэл энэ үед Хөгжлийн банкны тухай хуулийн төслөө батлах нь гэрээ хэлцэл хийхэд хүндрэл учруулна хэмээн болгоомжилж байгаагаа дуулгав. Учир нь ОУВС-тай хэлэлцэж байгаа асуудлын тодорхой хувь нь Хөгжлийн банктай холбогдож байгаа юм. Энэ талаар УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатар "Хөгжлийн банктай холбоотой хууль дотор байгаа хэд хэдэн заалтууд одоо ОУВС-тай хийж байгаа гэрээ хэлцэлтэй холбоотой. Тиймээс ОУВС-тай гэрээ хийж байгаа энэ цаг мөчид Хөгжлийн банкны тухай хуулийг шууд батлаад явах нь өөрөө Засгийн газар ОУВС-ийн хоорондын гэрээ хэлэлцэлд ихээхэн саад учруулна гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хамтарч ажиллах талаар ярилцаж байгаа хэрнээ тэр гэрээнд нь тусах зүйлийг нь урьдчилаад хууль болгоод, баталж байгаа нь Монголын Засгийн газрыг хэлж ярьж байгаа зүйлдээ тууштай биш, хуурах гэсэн оролдлого юм шиг харагдуулж байна" гэлээ. Тиймээс ч хуулийн төслийн хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулж өгөөч гэсэн хүсэлт тавьсан юм. Х байнгын хорооны дарга Д.Тэрбишдагва санал хураалгасангүй. Ингэснээр хуулийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжүүлж, ажлын хэсгээс оруулж ирсэн зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулсанаар Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан түр завсарласан юм.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

П.СЭРГЭЛЭН: Хоршооны хөгжлийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжинэ

Ж.МЯГМАР

ХХААХҮЯ, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо, хоршоодын холбоод, хоршоог дэмжигч байгууллагуудтай хамтран "Үндэсний хоршоологчдын V чуулган"-ыг "Хоршоодын бизнесийн хөгжлийн гарц" сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Чуулга уулзалтад ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, УИХ-ын гишүүн, Монголын Хоршоодын Үндэсний Нэгдсэн холбооны тэргүүн Н.Энхболд, КХХ-ны "Инвест ко-оп" хөтөлбөрийн Монголын талыг хариуцсан менежер Катрин Кларк болон нийслэл, хөдөө орон нутгаас ирсэн төлөөлөгчид оролцлоо. Чуулганыг нээж ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн "Манай улсад зах зээлийн үеийн хоршооллын хөдөлгөөн, хоршооны мөн чанар, үнэт зүйлс болон үндсэн зарчим нь өмнөх тогтолцооны үеэс эрс өөрчлөгдөн, ард иргэдийн өөрсдийнх нь хэрэгцээ сонирхолд тулгуурласан сайн дурын үндсэн дээр олон улсын нийтлэг жишгийн дагуу 20 гаруй жил хөгжиж байна. Хөрөнгө хөдөлмөрөөрөө хоршиж, хамтарч үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нь бүтээмжийг өсгөх, илүү их баялаг бүтээх бололцоо олгож, ажлын байр нэмэгдүүлэх, хомсдлыг даван туулах зэргээр нийгэм эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Төр засгаас хоршооллыг олон улсын түгээмэл зарчимд нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөтөлбөр гаргаж дэмжлэг үзүүлэх, гадаад орон, олон улсын байгууллагын зээл тусламж, төсөл хөтөлбөрүүдийг хоршоодод чиглүүлэх бодлого барин ажилласаар ирлээ. Хоршоог хөгжүүлэх нь манай орон шиг хүн ам цөөтэй, зах зээлийн багтаамж багатай, өргөн уудам газар нутагтай хөгжиж байгаа орны хувьд богино хугацаанд боломжийн зардлаар олон ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үр ашигтай сонгомол арга юм. Иймд Засгийн газраас хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, хоршоодын үйл ажиллагааны давуу талыг ашиглан жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-II"-ийг боловсруулж, батлан хэрэгжүүлж байна" гэв Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хоршооллын салбарын эрх зүй, нийгэм, эдийн засгийн таатай орчин бүрдэж, ажил эрхлэлтийн төвшин нэмэгдэж, хоршооны гишүүдийн орлого, амьдралын түвшин дээшилнэ гэж үзэж байгаа аж. Мөн хоршооны хөгжлийг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжсэнээр хоршоод болон гишүүдийн тоо өсч, хоршоодын салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ борлуулалт нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ өснө гэж харж байгаа юм байна. Хоршоодын хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг хамтран хэлэлцсэн уг чуулганд "ЖДҮ, хоршооны талаар төрөөс баримтлах бодлого 2016-2020 он", "Хоршооллын хөдөлгөөний хөгжлийн чиг хандлага", "Хоршооны удирдлагын манлайлал", "Мах сүүний анхдугаар аян"-ы зорилго, чиглэл үйл ажиллагаа зэрэг сэдвүүдээр итгэл тавигдлаа. Энэ үеэр УИХ-ын гишүүн, МХҮНХ-ын тэргүүн Н.Энхболд "Манай улсад 4200 гаруй хоршоо байна. Бид хоршооны зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулж эхэлбэл тийм ч дутагдалтай зүйл биш. Гэхдээ хоршоо ямар байх ёстой, зарчим, үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл дутмаг байгаа нь үнэн. Хоршооллын Нэгдсэн холбооны дэргэд сургалт мэдээллийн төв сүүлийн 10 жил нэлээд идэвхтэй ажиллаж байгаа. Өөрсдийн хүчин чадлаараа сургалт зохион байгуулдаг ч хоршоод бүрт хүрч ажиллаж чадахгүй байна. Гэхдээ бидний сургалт мэдээлэл хийж ажилласан хоршоод, зарчмаа ойлгож одоо үйл ажиллагаагаа нь хэвийн явагдаж байна. 1990 онд хоршоодыг татан буулгаснаас хойш ерөнхийдөө 10 гаруй жил хөвж явсан. Харин сүүлийн 10 гаруй жил чадлынхаа хэрээр хоршооны давуу талыг ойлгуулж, ярьж хүмүүст хүргэж байна. Нэгэнт бүгдэд нь хүрч ажиллаж чадахгүй учраас төлөөлөл болгон хоршоодыг сайн ажлуулж бусад хоршоодод үлгэр дуриалал болгох журмаар ажиллаж байна. Үүнд төр засгийн баримталж байгаа зарчим их чухал юм. 2008-2012 онд хоршоог дэмжих зорилгоор нэлээд бодитой арга хэмжээг авч, тодорхой хэмжээнд хөрөнгө санхүүг туслалцаа болгож өгсөн, сургалтуудыг сайн зохион байгуулсан. Тэр үед үр дүн гарч эхэлж байсан. Тэгээд Засгийн газар солигдох үед хаана харьяалагдах нь мэдэгдэхгүй хоёр гурван газар нэртэй явж байсан. Одоо харин Засгийн газар, ХХААХҮЯ хоршоодын асуудлыг хариуцаж нэлээд цэгцтэй болж байна. Нэг талаас Засгийн газар ХХААХҮЯ, нөгөө талаас хоршоодын холбоод хамтарч ажиллаад эхлэхэд нэлээд сайн үр дүн үзүүлэх байх гэж бодож байна" хэмээлээ.

MINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОР 9999

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Засгийн газрын үйл ажиллагаанд аудит хийнэ

Ерөнхий Аудитор Д.Хүрэлбаатар 2017 онд Засгийн газрын үйл ажиллагаанд аудит хийх тухай ойлголтын захидал болон гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат болон Засгийн газрын гишүүд, яамдын сайд нарт гардууллаа. Ерөнхий Аудитор Д.Хүрэлбаатар хэлэхдээ "Бид хуулийн дагуу олон улсын стандартад нийцүүлэн аудит хийнэ. Аудит хийх хуулиар олгогдсон хугацаанд сахилга батад анхаарч, харилцан хүлээсэн үүргээ ухамсарлаж ажиллана гэдэгт итгэж байна" гэлээ. Аудитын байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны эхний хагас жилд Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн гүйцэтгэл, Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн биелэлт, үр дүн, үр ашиг, Засгийн газрын өрийн удирдлагын биелэлт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөсөн байна.

ШАР Мэдээ

Ц.Нямдорж монголын бүх сэтгүүлчидийг доромжлов

Ж.ӨӨДЛӨН

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Сүүлийн үед Ц.Нямдорж гишүүнийг ганц шоу хийдэг асуудал нь "Эрдэнэт" үйлдвэрийн 49 хувь болчихоод байгаа. Хэдийгээр энхийн цагаан тагтаа шиг зүйл яриад яваад байгаа ч саяхан тэрбээр хүүгээ "Эрдэнэт"-д шахаа хийхэд нь тусалсан талаараа ам алдчихсан. Тодруулбал, Ц.Нямдоржийн хүү Н.Анхбаярын "Анлимитед" буюу "Хязгааргүй" гэх компани 2004 болон 2006, 2007 онуудад "Эрдэнэт" үйлдвэр рүү бараа нийлүүлэх гэрээ хийж, зах зээлийн үнээс зургаа дахин өндөр үнээр "шахсан" түүхтэй. Тэгвэл тэрбээр байнгын хорооны хуралдааны үеэр "Эрдэнэт" үйлдвэрийн шахаачдыг хаацайлж, сэтгүүлчдийг худалдагдсан хэмээн доромжлоод авлаа. Тэрбээр "Нэгдүгээрт, асар их мөнгө хаяж сөрөг мэдээлэл тарааж байна. Бүх сэтгүүлчидтэй, бүх телевиз, сонингуудтай хаалтын гэрээ хийсэн байгаа. Хоёрдугаарт, энэ нэг шахаа махаа шалгана гэж яриад байгаа. Шалгалтын ажлын хэсэг Эрдэнэтийн 49 хувийн л хувьчлалыг шалгана" гэлээ. Үүнээс харж байхад энэ удаагийн УИХ-ын ажлын хэсэг "Эрдэнэт"-д хийдэг байсан шахааг буюу Ц.Нямдоржийн хүү Н.Анхбаярын хүүгийн асуудлыг ярихгүй, шалгахгүй гэнэ.

Н.Учрал хүүхдийн сувилалын үйл ажиллагааг эхлүүлж өглөө

Нийслэлд хүүхдийн клиник сувилал гурав байдаг. Үүний нэг нь Сонгинохайрхан дүүргийн суурь өвчтэй 1-2 насны хүүхдүүдийг хүлээн авдаг клиник сувилал юм. Тэгвэл тус сувилалын шинэ байрны өргөтгөл 2016 онд ашиглалтад орсон юм байна. Гэвч тавилга хэрэгсэл, гал тогооны хэрэгсэл, хүүхдийн тоглоом, хүүхдийн ор зэрэг тохижилтод зориулсан төсөв мөнгө тавигдаагүй гэнэ. Тиймээс хов хоосон барилга дотор үйл ажиллагаа явуулж чадахгүй нь ойлгомжтой. Ийнхүү төсөв мөнгө нь шийдэгдэхгүй сунжирсаар өнгөрсөн нэгдүгээр сарыг гартал ажиллах боломжгүй байжээ. Иймээс Сонгинохайрхан дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүн Н.Учрал өөрийн зүгээс тус хүүхдийн сувилалд гал тогооны хэрэгсэл, зөөлөн тоглоомууд хандивлажээ. Түүнчлэн БСШУСЯ-ы дэргэд байдаг тус сувиллын харьяаллыг ЭМЯ-нд шилжүүлэх талаар сайдад уламжилсан байна. Ийнхүү шилжүүлснээр багш, сувилагчдын цалингийн нэмэгдэл шийдэгдэх аж. Мөн зуны сарын хугацаанд хүүхдүүд авах боломжтой болох болох юм байна. Энэ үеэр УИХ-ын гишүүн Н.Учрал "Уг сувилал маань өргөтгөлийн шинэ байрандаа хүүхдүүдээ хүлээн авах гэтэл доторх тавилга хэрэгсэл, ор дэр, гал тогооны тавилгууд гэх мэт маш олон зүйлүүд дутуу байсан. Гэхдээ уг сувилалын тохижилтод олон сайхан сэтгэлтэй хүмүүс туслалцаа дэмжлэг үзүүллээ. Тухайлбал, дүүргийн засаг дарга болон олон төрийн бус байгууллагууд тусалсан. Миний хувьд гал тогооны дутуу хэрэгслүүдийг авч өгч бэлэглэлээ. Суурь өвчтэй хүүхдүүд зөөлөн тоглоомоор тоглодог. Гэтэл ийм тоглоомгүй байсан. Энэ тоглоом болон бусад шаардлагатай зүйлүүдийг мөн өглөө. Үүний үр дүнд хүүхдүүд маань хэвийн тохь, тухтай нөхцөлд хүмүүжих боломжтой болж байна" гэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын 60 мөр

НӨАТ-ын баримтаа шалгаж аваарай

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Саяхан “Миний Хайпермаркет”-аар үйлчлүүлэв. Нийслэл хотын энд тэндгүй салбартай тус сүлжээ дэлгүүрээс худалдан авалт хийж, баримтаа ч марталгүй авлаа. Гэтэл өнөөхөө бүртгүүлтэл “Үнийн дүн зөрүүтэй” гэх тайлбар гарч ирснээс хойш хэд хоногийг үдэв.

Эцэстээ хэдэнтээ бүртгүүлснийхээ дараа баримтаа сайтар ажиглавал “Ebarimt-д бүртгүүлэх дүн, НӨАТ-тай, НӨАТ-гүй дүн гэх мэтээр ялган бичсэн байх нь тэр. Гэтэл үнэндээ “НӨАТ” ороод 19810 төгрөгийн худалдан авалт хийсэн байтал Ebarimt-д бүртгүүлэх дүн нь 10930 гэж бичсэн байв. Миний халааснаас 20 орчим мянган төгрөг гарсан байтал үнэн хэрэгтээ баримтаа бүртгүүлэх үедээ 10 мянга гэж бичих нь тун инээдтэй хэрэг биз. Би худалдан авалт хийсэн, тэр дүнгээ ч бүртгүүлэх эрхтэй. Гэвч чухам ямар шалтгаанаар ийм явдал болсныг ч “Миний дэлгүүр”-ийн төв салбар руу нь утас цохиж лавласнаа надтай яг ижил байдалд орсон уншигч танд ч бас хуваалцая. Тэдний хувьд ямар учраас төлсөн дүн, “Ebarimt”-д бүртгүүлэх дүн ялгаатай байгаа талаар “Таны худалдан авсан бараан дунд доогуур нь зурсан бүтээгдэхүүн байна уу. Тэр бүтээгдэхүүний үнийн дүнд НӨАТ ороогүй учир бүртгүүлэх дүнгээс нь хасагдсан байгаа” гэх тайлбарыг хэллээ. Тухайн сүлжээ дэлгүүрийн лангуу дээр зарагдаж байгаа бүтээгдэхүүнийг худалдан авч, төлбөрийг нь төлсөн ч “доогуур нь зурсан” гэх барааны үнэ НӨАТ-ын хууль журмын дагуу бүртгэгдэхгүй нь. Ийм байдалд орсныхоо дараа “Сансар”, “Номин” гэх мэт супермаркетуудаар ч орж, бүтээгдэхүүн авч үзлээ. Лав л худалдан авалт хийсэн дүн бүртгүүлэх дүн хоёр хоорондоо зөрсөнгүй. Харин “Миний дэлгүүр”-ийнхний зөрүүтэй баримтад хууль хяналтынхан нь нэг тайлбар хэлэх биз. Өөр нэгэн жишээ дурьдая. Баруун аймаг руу зорчихоор “Драгон” төвд очиж автобусны тасалбараа бичүүлсэн юм. Тасалбарын үнэ нь 27000, амь даатгал нь 500. Нийтдээ 27500 төгрөг тушааж, НӨАТ-ын баримт ч авлаа. Гэтэл бүртгүүлэх дүн нь бас л зөрүүтэй. 27500 төгрөг тушаасан байхад бүртгүүлэх дүн нь 2160 байх юм. НӨАТ-ын хууль өнгөрөгч онд л хэрэгжиж эхэлсэн гэдэг утгаар нь иргэд баримтаа хаяа л бүртгүүлж, зарим нь огт бүртгүүлж ч байгаагүй болов уу. Гэтэл өнгөрсөн 2016 оны тоо баримт энэ хууль ямар үр дүнтэй, хэрэгтэй байсныг гэрчилсэн. Тухайлбал, өнгөрсөн онд татварын төлөвлөгөө давж биелсэн. Өмнө нь НӨАТ хэзээ ч төлөвлөгөөндөө хүрч биелж байгаагүй юм билээ. Харин 2016 онд 100 хувь давж биелсэн. Улсын төсөвт татвараас нэг их наяд 560 тэрбум төгрөг орсны 35 хувь буюу 555 нь НӨАТ-аас орсон мөнгө байх жишээтэй. Дээрээс нь өнгөрсөн онд НӨАТ төлөгчөөр 2708 аж ахуйн нэгж бүртгүүлсэн байгаа бөгөөд энэ нь хэд дахин өндөр үзүүлэлт байв. Энэ бүхэн НӨАТ-ын хууль хэрэгжсэний гавьяа. Ер нь 2017 оны төсөв тасарчихалгүй бүрдсэний нэг чухал хүчин зүйл нь НӨАТ байлаа. Гэтэл зарим нэг аж ахуй нэгжүүд энэ мэт асуудал гаргасны улмаас иргэдийн төлсөн дүн, бүртгүүлэх дүн хоорондоо зөрж буйг холбогдох албаныхан нь анхааралдаа аваарай. Харин иргэддээ хандаж хэлэхэд, баримтынхаа дүнг заавал шалгаж байхыг хүсье.

...Бид Б.Дэлгэрсайхан шиг Сэлэнгийн Ерөө сумын нутаг, Минжийн хангайн салбар уулсын нэг сүрлэг Хандгайт уулыг тал болтол нь талхлан нурааж, уутлан Хятад руу гаргаж цөм баяжаагүй. Хэрэв түүн шиг баяжсан бол 100 бус тэрбум төгрөг бариад зогсч байх байсан юм...

НАМ, АЛБАН ТУШААЛД ӨГДӨГ МӨНГӨНӨӨСӨӨ ЭХ ОРОНДОО ХАНДИВЛАНА УУ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Эл мэдээллийг уншсан зарим нь хандив өргөгчдийг “Энэ цагийн эх оронч ид” хэмээн магтан сайшааж байхад нөгөө талд өгсөн хандивыг нь голж, элдвээр хэлж сууна. Хэсэг нөхөд “Солонгосын ард түмэн ээмэг, бөгжөө тайлаад өгч байсан юм гэнэ лээ. Бид нэг өдрийн цалингаа хандивлаж яагаад болохгүй гэж” гэцгээн бусдыгаа уриалж сүйд болж байхад “Манайх ямар Солонгос шиг дайнд ороод ядарсан биш хэдэн авилгачид, оффшорчид улсаа хямраагаа биз дээ. Тэдний өрийг ард түмэн төлөх юм уу, горьд” хэмээн эсэргүүцэх нь цөөнгүй. Үнэндээ цаг нь ирвэл ээмэг, бөгж байтугай халуун амь бүлээн цус, хүү, охиноо илгээх сэтгэл зүрх бидэнд бий. Гэвч өнөөгийн нөхцөл байдлыг Солонгостой харьцуулж үл болно гэдэг нэгийг бодогдуулах. Монгол Улсад дайн болоогүй, газар хөдөлж, гамшигт нэрвэгдээгүй. Гагцхүү цадаж ханахыг үл мэдэх хэдхэн хүн л улсын эдийн засгийг ийм байдалд оруулсан бус уу. Хатуу хэлэхэд, төрөөс төрсөн тэрбумтнууд төрийн дансыг улайлгаж орхисон биз дээ. Тэд яагаад таг дуугүй байна. Баялаг бүтээх нэрийн дор гаднаас орж ирсэн зээл тусламжийн ихэнхийг нь залгиж орхисон зарим компанийн захирлуудын гараа сунгах цаг үе бус уу. Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк болон бусад санхүүгийн эх үүсвэрээс орж ирсэн мөнгө хэний гараар орсон юм бэ. Эгэл жирийн иргэд орон сууцны найман хувийн зээл авах гэж үйл тамаа үздэг байтал орж ирснийг нь Засгийн газраар баталгаа гаргуулан байж хуваж авчихаад төлөх болохоороо төр, засаг ард түмэндээ нялзайчихдаг нөхдийн өмнөөс ядарсан ард бид өр төлмөөргүй байна. Бас хүүхдийнхээ хоолны мөнгөнөөс илүүчилж, хандив өргөх хүсэл хэн хүнд ч байхгүй ээ. Бид Б.Дэлгэрсайхан шиг Сэлэнгийн Ерөө сумын нутаг, Минжийн хангайн салбар уулсын нэг сүрлэг Хандгайт уулыг тал болтол нь талхлан нурааж, уутлан Хятад руу гаргаж цөм баяжаагүй. Хэрэв түүн шиг баяжсан бол 100 бус тэрбум төгрөг бариад зогсч байх байсан юм. Тэр тэрбумыг өгсөн бол хэн ч гоочлохгүй байж мэднэ. Бид бас Ажнайн Д.Бат-Эрдэнэ шиг Монголын ард түмний шимийг нь хүртэх учиртай газрын баялаг нүүрсийг экспортлож, зөөж баяжаагүй. Үнэндээ бидэнд улстөржиж, намдаа хандив өргөн албан тушаал худалдаж авах мөнгө байхгүй. Харин намдаа хандив өргөн албан тушаалд томилогдсон гэх сайд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга нар, төрийн өмчит аж ахуйн нэгжийн захирлууд, аймаг нийслэл, дүүргийн газар хэлтсийн дарга нараасаа эх орондоо хандив өргөнө үү гэж уриалмаар байна. Сайд болох гэж 400 саяыг өгдөг цаг өнгөрч хэдэн тэрбум хүрсэн тухай хэвлэлээр хангалттай л бичиж байна. Улстөрчид УИХ-ын сонгуульд нэг бус гурав дөрвөн тэрбум төгрөг зарцуулдгийг бид мэднэ. Нам, намын удирдлагадаа 20, 200 саяыг атгуулж чадсан нь яам, тамгын газрын газар, хэлтсийн дарга болдог нь нууц биш болсон биз дээ. МАН албан тушаалын томилгооноос 60 тэрбумыг босгоно гэж ярьсан нь үүнийг баталгаажуулсан хэрэг гэж хэн хүнгүй ярьж байна. Тэд бас нэгийг бодоосой. Саяхан болж өнгөрсөн АН-ын даргын сунгаанд тус бүрнээ 250 саяыг төлсөн нэр дэвшигчид 25 сая төгрөг бариад зогсч байвал нэр төрийн хэрэг бус уу. Түүнчлэн сардаа 30 сая төгрөгийн цалин авдаг албан тушаалтнууд яагаад чэмээгүй байна вэ. Өнөө төрийн монополь компаниуд хаачив. Гэхдээ тэдний ажилчид бус эзэд нь хандив өргөх ёстой санагдана. Тэд баялаг бүтээгээгүй, төрийн өмчийг өөрийн болгож чадсан учраас өдөж буй хэрэг. Тэр бүү хэл, тэр их өрнөөс хуваалцчихаад Засгийн газрын шийдвэрээр хөнгөлөлт эдэлсэн “Монполимет” тэргүүтэй 22 компани хамгийн түрүүнд дуугарч, ард түмэндээ үүрүүлэх гэж шоудаад байгаа ачаанаас өөрсдөө үүрчихэд л Монгол Улсын эдийн засгийг аврах хандив нь болох бус уу. Ингэвэл ард түмэн өөрөөр хандах болох юм шүү. Үнэндээ улсаа бодохул хандив өгчихмөөр байвч, авлигачид оффшорчдыг санахаар, улс орныг минь хэн ийм байдалд оруулсан билээ гэж бодохоор горьд гэвэл сууж баймаар байна хэмээн хэн хүнгүй ярьж, ард түмэн ч толгой нь эргэчихсэн мэт байна даа. Дээр цухас дурдсан МАН-ын шоу битгий байгаасай гэсэн нь улсдаа хандив өгөөч гэж албан ёсоор төр засаг ард түмэнд хандаагүй байгаа, зарим албаны хүний яриагаар Монголын төр ард түмнээсээ хандив гуйхаар дор орчихоогүй байгаа гэх юм. Ядаж газрын баялаг алт бий гэсэн дээ.

Э.НОМИНЧУЛУУН: Багануурын уурхай 2018 онд нийслэлийг утаагүй түлшээр хангаж эхэлнэ

Багануур ХК-ий гүйцэтгэх захирал Э.Номинчулуунтай ярилцлаа.

-Багануур ХК өнгөрсөн 2016 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бүхнээ амжилттай биелүүлсэн. Аж ахуйн нэгжийг удирдаж байгаа хүний хувьд таны сэтгэл өндөр байгаа байх.

- Тийм ээ, хамт олныхоо хийсэн бүтээсэнд миний сэтгэл өндөр байна. Бид 2016 онд 31.5 сая м/куб хөрс хуулж, 3.8 сая тонн нүүрс олборлон борлуулсан нь төлөвлөгөөт зорилтоо 100 хувь биелүүлсэн гэсэн үг. Төлөвлөгөө биелэх гол хүчин зүйл нь нэгдүгээрт, төлөвлөсөн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийсэн хоёрдугаарт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зохион байгуулалт болон ажлын уялдаа холбоо сайн байсан гуравдугаарт, туршлагатай бүтээлч хамт олны ажлын үр шимээр төлөвлөсөн төлөвлөгөөгөө амжилттай биелүүлсэн гэж Багануур ХК-ий гүйцэтгэх захирлын хувьд дүгнэж суугаа.

-Тун удахгүй монгол тооллоор шинэ он гарна. Хийж бүтээхээр төлөвлөсөн ажил, 2017 оны зорилтыг тань сонирхвол?

-Багануур ХК 2017 оныг үр ашиг хэмнэлтийн жил болгон зарласан. Компанийн хэмжээнд нэгдсэн хэмнэлтийн төлөвлөгөөг бодит судалгаан дээр үндэслэн боловсруулж, энэ хоёрдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлнэ. Мөн компанийн ажлын байрны соёл бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулж баталсан ТЭЗҮ-ийн дагуу анхан шатны хөрөнгө, санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд гол анхаарлаа хандуулж ажиллахаар төлөвлөн ажлаа эхлүүлсэн гэдгийг энд онцлон дурьдах ёстой байх. Түүнчлэн ТЭЗҮ-тэй уялдаатай төсөл хөтөлбөрүүд нэлээд бий. Эдгээр төслүүдийг нэвтрүүлэх зорилго тавьсан.

-Төсөл хөтөлбөрүүдийнхээ талаар дэлгэрүүлж хэлбэл?

-“Эд ангийг сэргээн засварлах”, “Ус шүүрүүлэхийг шинэчлэх”, “Уулын дэд станцын нүүлгэн шилжүүлэлт” төслийг хэрэгжүүлэх зорилго тавьснаас гадна утаагүй түлш гаргах төслийг энэ оноос судлаж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

-Утаатай хэрхэн тэмцэх талаар байгууллага, аж ахуйн нэгж бүр шинийг санаачлахын төлөө ажиллаж байгаа энэ үед та бүхний хэрэгжүүлэх утаагүй түлшний төслийн үр дүн миний сонирхлыг ихээхэн татаж байна?

-Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын агаарын бохирдлын асуудал үндэсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц гамшгийн хэмжээнд хүрээд байгаа энэ үед утаагүй түлшний үйлдвэрлэлийнхээ талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболдтой нэгдүгээр улиралдаа багтаж санамж бичиг үйлдэхээр төлөвлөсөн байгаа. Мөн утаагүй түлшний үйлдвэрлэлийн төслийг хэрэгжүүлж үйлдвэрлэл явуулах бэлэн объект манай компанид бий. Утаагүй түлш үйлдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах санал тавьж буй энэ чиглэлийн бэлэн болсон төсөлтэй компаниуд ч байгаа. Тиймээс шууд бэлэн болсон төслийн хөрөнгө мөнгийг нь шийдээд хэрэгжүүлье гэсэн бодолтой явна. Энэ нь манай компаний нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын нэг хэлбэр юм шүү дээ.

-Ер нь утаагүй түлш бол нийслэлчүүдийн хувьд нэн даруй шийдэх асуудлын нэг. Тиймээс 2017 онд утаагүй түлш үйлдвэрлэх төсөл хэдэн хувьтай хэрэгжих бол, яг хэзээнээс Багануур ХК нийслэлийг утаагүй түлшээр хангах бол хэмээн уншигчид маань сонирхох нь дамжигтүй?

-Ер нь дээр хэлсэн Санамж бичгт гарын үсэг зурчих юм бол ирэх наймдугаар сараас үйлдвэрлэлээ эхлүүлэх бололцоо бий. Ингэж чадах аваас жилдээ 100 мянган тонн перкит буюу утаагүй түлшийг нийслэлийн зах зээлд нийлүүлэх ийм боломж харагдаад байгаа юм.

-Эрчим хүчний зориулалттай нүүрсний уурхайнууд нүүрснийхээ үнийг нэмэх санал гаргадаг ч амжилт олдоггүй. Таны хувьд асуудалд ямар өнцгөөс хандаж байгаа вэ?

-Өнгөрсөн 2016 оны эхэнд болон оны сүүлд төрийн оролцоотойгоор нүүрсний үнийг хоёр удаа нэмсэн. Одоогийн байдлаар манайхаас станциудад нийлүүлэх тонн нүүрсний үнэ 29500 төгрөг. Жижиг хэрэглэгчдэд 35750 төгрөгөөр нийлүүлж байгаа. Үнийн асуудлыг Эрчим хүчний зохицуулах хорооноос шийдвэрлэдэг. Эрчим хүчний зохицуулах хорооныхон намайг ажил аваад 10-аад хонож байхад ирж уулзсан. Тэгэхэд “Засгийн газар хүлээсэн үүргийнхээ дагуу нүүрсний үнийг зохих хэмжээгээр нэмэгдүүлж явах хэрэгтэй. Гэхдээ огцом 2000-3000 төгрөгөөр нэмэхгүйгээр улиралд 500 төгрөгөөр нэмэхэд иргэдийн амьдралд бага нөлөөлнө” гэх саналыг хэлсэн. Багануур ХК тонн нүүрс олборлох өөрийн өртөг 31000 төгрөг, тонн тутамд 2000 орчим төгрөгийн алдагдалтайгаар олборлолт явуулдаг. Тиймээс нүүрсний үнийг бага багаар нэмэх л хэрэгтэй байгаа юм.

-Багануур ХК нийгмийн хариуцлагын хүрээнд ямар, ямар ажил хийхээр төлөвлөж байна. Дүүрэгтэй хэрхэн хамтран ажиллах вэ?

-Багануур дүүргийн Засаг даргатай санал солилцоод 2017 онд нийгмийн хариуцлагын хүрээнд өнгөрсөн нэгдүгээр сарын 26-ны өдөр Санамж бичиг үйлдсэн байгаа. Энэ нь төр, захиргааны зүгээс манай компанид болон ажилтнуудад дэмжлэг үзүүлэх боломжтой эсэх, нөгөө талаас дүүргийн цохилох зүрх нь болсон уурхайн зүгээс иргэдэд ямар тус дэм үзүүлэх талаараа тохиролцож чадсан гэсэн үг. Манай компаний удирдлагын баг шинээр бүрдсэн бөгөөд хүүхэд, залуучууд, ахмадын зөвлөлүүдийнхээ үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах зорилт тавьсан. Мөн архидалтын асуудалд анхаарал тавьж, нийгэмд болоод дүүрэгт хэрхэн үлгэр дууриал болж ажиллах талаар ярилцаж, шийдэлд хүрч чадлаа. Тухайлбал, Архидалтын эсрэг ассоциаци зэрэг төрийн бус байгууллагуудтай хамтран дүүргийн байгууллага аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудад, дүүргийн иргэдэд архидалтын эсрэг сургалт сурталчилгаа хийж, соён гэгээрүүлэх, ухааруулах, амьдралын чиг шугамыг учир утгатай болгох талруу чиглэсэн ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

-Нийгмийн хариуцлагын хувьд тодорхой ажлууд төлөвлөжээ. Харин уурхайчдынхаа нийгмийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж ажиллах вэ?

-Ажилтнуудынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхийн төлөө манай үе үеийн удирдлагууд тодорхой ажлыг хийсээр ирсэн. Өнгөрсөн онд уурхайчдын орон сууц барих ажлыг эхлүүлсэн авч орон сууц барих газар нь хууль зөрчиж олгогдсон байсан. Тиймээс 2017 онд санамж бичгийн хүрээнд дүүргийн төр, захиргаанаас хуулийн дагуу шийдвэрлэж өгье гэсэн. Газрын асуудал шийдэгдэх аваас ажилчдын орон сууцны барилгын ажлыг шууд эхлүүлнэ. Мөн ажилчдынхаа цалинг энэ оны хагас жилээс тодорхой хэмжээгээр нэмэх асуудлыг шийдвэрлүүлэхээс гадна эрүүл мэндэд нь анхаарч энэ чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

ДЭЛХИЙ

ФИЛИППИН ДЭХ АЛЛАГА

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Эмнести интернэшнл байгууллага Филиппинд өрнөж буй цуст аллагын талаарх тайлангаа ийнхүү танилцуулсны дараа Засгийн газраас ямар нэг тайлбар хийгээгүй байна. Гэхдээ Филиппиний цагдаагийн газраас урьдын л адил "баривчилгааг эсэргүүцсэн сэжигтэн рүү л гал нээсэн" хэмээн хаацайлж байжээ. Тайланг гаргахдаа хүний эрхийн байгууллагынхан гэрчүүдийн мэдүүлэг болон хараат бус мөрдөх багийнхны хийсэн ажлын үр дүнд үндэслэсэн байх бөгөөд түүндээ "Хар тамхины гэмт хэргийн сэжигтнүүдийг санаатайгаар олноор нь амийг нь бүрэлгэх үйл ажиллагааг холбогдох албаныхан төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж буйд гүнээ харамсаж" буйгаа илэрхийлсэн байлаа. Учир нь цагдаа нар ихэвчлэн шөнө дундын үед айлын хаалгыг тогшиж, үүнийхээ дараа хар тамхи зарсан эсвэл хэрэглэсэн гэх хэрэгт сэжиглэгдэж буй ямар ч зэвсэггүй хүнийг буудан хөнөөдөг байна. Түүнчлэн, зарим гэрчүүдийн хэлснээр хар тамхины хэргийн сэжигтнүүд өвдөг дээрээ сөгдөн, аль эсвэл өөр байдлаар бууж өгч буйгаа илэрхийлэн амь өршөөхийг гуйж байсан ч, цагдаа нар үл тоон цохон дундуур нь буудаж орхидог ажээ. Харин үүнийхээ дараа цагдаагийнхан нотлох баримт зохиож, хүн амины хэргээ далдлах хуурамч дүгнэлт үйлддэг гэнэ. Хүний эрхийн байгууллагынхны онцолж буйгаар үүний цаана хөрөнгө мөнгөний асар их сонирхол байж магадгүй аж. Тодруулбал, нас барсан гэмт хэргийн сэжигтнийг оршуулах төлбөр болгон ар гэрээс нь мөнгө авахаас эхлээд амиа алдсан хүн нэг бүрээр тооцон "ширээн доогуур"-аа урамшуулал авдаг байх юм. Үүнийг нэг цагдаагийн офицер мэдээлжээ. Түүнчлэн, амиа алдсан гэмт хэргийн сэжигтнүүдийн ихэнх нь ядуус байх бөгөөд "Хар тамхины гэмт хэрэгтнүүдийн жагсаалт"-ыг холбогдох албан тушаалтан урьдаас бэлтгэн цагдаа нарт дамжуулдаг байна. Тус жагсаалт нь учир дутагдалтайн зэрэгцээ олон нийтийн дунд тархсан дам яриа, цуу үгэнд үндэслэж гаргасан байдаг ажээ.

Ямартай ч, энэ мэт асуудлыг иргэний нийгэм, шашны байгууллага, Засгийн газрын гишүүн, цагдаагийн ажилтан, хар тамхи хэрэглэгч, амиа алдагсдын хамаатан садан, гэрчүүд гэжээ нийт 110 орчим хүний ярьсанд үндэслэн Эмнест Интернэшнл байгууллага ил болголоо. Родриго Дутерт хар тамхины эсрэг дайнд хатуу чиг шугамыг баримталж буй. Тэр ч утгаараа барууны зарим орны эсэргүүцэлтэй тулгарах болсон юм. Гэхдээ хүүхдийн хулгай асар их хувиар нэмэгдэж, Өмнөд Солонгосын бизнесмэн алуулсны дараа л М.Дутерт авлигач цагдаа нарыг хүлээн зөвшөөрөх эсэх асуудалтай нүүр тулгарлаа. Тиймээс ч, хар тамхины эсрэг дайнаа зогсоож, дахин зохион байгуулалт хийх шийдвэрт хүрчээ.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗЭД КОМПЬЮТЕР ГРАФИКЧ, ДИЗАЙНЕР СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байранд тавигдах шаардлага:
- Компьютер графикч, дизайнер мэргэжлээр их дээд сургууль төгссөн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Photoshop, Premiere, After effect, 3D MAX, Eduis программууд дээр ажилладаг байх
- Интерьер, экстерьер дизайн, хэвлэлийн эх бэлтгэл, видео эвлүүлэг болон дуу, дүрсний эффект, компьютер график ашиглан мэргэжлийн өндөр түвшинд промо, реклам, шторк зэргийг хийх чадвартай байх
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

Бүрдүүлэх материал:
- Өөрийн хийсэн 3 бүтээлийг "dvd"-нд хуулбарлаж өгөх
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн бүтүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг
Хувьсгалчдын зам-3
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
Хүний нөөцийн алба
Утас: 325802

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД ХУУЛИЙН ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага:
- Хууль, эрх зүйн чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх
- Хууль, эрх зүйн онолын болон практикийн өндөр түвшний мэдлэгтэй, захиргаа, хөдөлмөр, иргэний эрх зүйн маргаануудад оролцож байсан туршлагатай
- Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан
- Хуульчийн сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй,
- Өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Их, дээд сургууль төгссөн дипломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Хуульчийн гэрчилгээ, Өмгөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон ёс зүйн, мэргэжлийн, сахилгын зөрчил гаргаж байсан эсэх тухай холбогдох байгууллагын тодорхойлолт
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн бүтүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
Хүний нөөцийн алба
Утас: 325802

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД ГАДААД ХАРИЛЦААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН БОЛОН МЭРГЭЖИЛТЭН СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага:
- Олон улсын харилцаа болон орчуулагч мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай
- Англи хэлний бичгийн болон ярианы дээд түвшний чадвартай байх
- Англи хэлнээс гадна, Олон улсын хэрэглээний хэлийг давхар эзэмшсэн байх
- Удирдах, зохион байгуулах авъяастай
- Гадаад харилцааны чиглэлээр удирдах албан тушаалд ажиллаж, гадаад улстай ажил хэргийн шугамаар харилцаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллага, хүмүүсийн тодорхойлолт

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн бүтүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, Хүний нөөцийн алба
Утас: 325802

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗЭД ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГА СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага:
- Хууль эрх зүй, Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй
- Хүний нөөцийн чиглэлээр удирдах албан тушаалд 3-аас дээш жил ажилласан туршлагатай, радио, телевизийн онцлогийн талаар мэдлэгтэй
- Англи хэлний дундаас доошгүй түвшний мэдлэгтэй
- Удирдан зохион байгуулах, хариуцлага хүлээх чадвартай
- Хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцэж гэрчилгээ авсан бөгөөд Хүний нөөцийн удирдлагаар мэргэшсэн бол давуу тал болно.

Бүрдүүлэх материал:
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн бүтүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
Хүний нөөцийн алба
Утас: 325802

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН ТЕЛЕВИЗЭД ЗУРАГЛААЧ СОНГОН ШАЛГАРУУЛЖ АВНА

Ажлын байранд тавигдах шаардлага:
- Зураглаачийн мэргэжил эзэмшсэн, дээд сургууль төгссөн, бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй
- Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан
- Дижитал, аналоги, хальсны болон дижитал зэрэг бүх төрлийн камерууд болон камерын кран, тэргэнцэр зэрэг дагалдах техникууд дээр ажиллах чадвартай байх
- Багаар ажиллаж, ачаалал даах чадвартай, харилцааны соёлтой
- Ажлын болон хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлага хүлээх чадвартай
- Тогтвор суурьшилтай ажиллах хүсэлтэй

Бүрдүүлэх материал:
- Өөрийн хийсэн 3 бүтээлийг "dvd"-нд хуулбарлаж өгөх
- Дэлгэрэнгүй анкет /www.mnb.mn сайтын "Бусад" гэсэн хэсэгт буй МҮОНРТ-ийн ажилтны анкетыг бөглөх/
- Их, дээд сургууль төгссөн диплом болон бусад материалыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт
- Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгчид дээрх материалыг бүрдүүлэн бүтүүмжилсэн дугтуйд хийж 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 17:00 цаг хүртэл хугацаанд доорхи хаягаар ирүүлнэ үү.

Хаяг: Баянгол дүүрэг, Хувьсгалчдын зам-3
Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
Хүний нөөцийн алба
Утас: 325802

ОНЦЛОХ ХУУДАС

Õýí íü õýí áý?

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖИЛД СЭТГЭЛ ОЮУНАА ЗОРИУЛАХ АН-ЫН БҮСГҮЙЧҮҮД

Ч.ЧУЛУУН

“Хэн нь бэ” булан нийслэлийн зургаан дүүргийн Засаг дарга нарыг онцолж байгаа билээ. Энэ удаад үргэлжлүүлэн нийслэлийн Баянгол, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн Засаг дарга нарыг онцлон танилцуулж байна.

БАЯНГОЛ ДҮҮРЭГ: С.ОДОНТУЯА

Энэ бүсгүйг монголчууд хэдийнэ танидаг болсон шүү дээ. Ахмад үеийнхэн Салдан сайдын охин гэдгээр, дунд үеийнхэн "Сентоза"-гийн бизнесмен гэдгээр, залуучууд имиж сайтай УИХ-ын гишүүн гэдгээр нь С.Одонтуяаг мэднэ. Ялангуяа, улс төр сонирхдог залуучуудын тухайд “Эдийн засгийн алуурчин” гэх сэдвийг хөндөж, улс төрийн сонгуулийн уриа лоозон болгож орж ирснийг өчигдөр мэт тод санадаг юм. Эдийн засагч мэргэжилтэй тэрбээр УИХ-ын гишүүнээр сонгогдсон даруйдаа л намын бүлгийн дэд дарга, хүн амын хөгжил, гэр бүл, хүүхдийн асуудал дэмжих лобби бүлгийн ахалж ажилласан билээ. Үнэндээ эрхэмсэг эл хатагтай 2012-2016 оны парламентийн өнгө зүс, нэрийн хуудас болсон цөөн бүсгүйчүүдийн нэг байв. Миний мэдэхийн хэлсэн үг нь байгаа олж, жинтэйхэн тусах нь бий. Улстөрчийн намтар түүхийн хувьд олон хуудас эргүүлэхүйц биш ч эдүгээ Засаг даргаар нь ажиллаж байгаа Баянгол дүүргийнхээ АН-ын дэд даргаар улс төрчийнхөө гараанд хөл тавьж, “Иргэн та баялаг сан”-г тэргүүлж, 2008-2012 онд НИТХ-ын тэргүүлэгч, Эрүүл мэндийн сайдын зөвлөх, АН-ын гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, 2012-2016 онд УИХ-ын гишүүнээр сонгогдон ажилласан байдаг. Өөчилж гоочлох нэг нь С.Эрдэнийг дагасандаа өдий зэрэгтэй яваа юм гэцгээдэг ч чухамдаа “Эрдэнэ” вангийн хошуунд ардчилал бөх бат оршин тогтнож байгаа тулгуур багануудын нэг нь С.Одонтуяа байж мэднэ. Тэр ч утгаар баянголчууд С.Одонтуяагаас салах дургүй.

Орон нутгийн сонгуулийн үеэр С.Эрдэнэ түүнийг Баянгол дүүргийн Засаг даргаар томилохоо албан ёсоор мэдэгдэхэд эсэргүүцэх хүн нэг ч гараагүй. Хувь хүнийхээ тухайд тэрбээр хүүхэд байхын нийгмийн идэвхи сайтай нэгэн байсан. Нийслэлийн арван жилийн Нэгдүгээр сургуулийг онц дүнтэй төгсч, ОХУ-ын Санктпетербург хотноо олон улсын эдийн засагч мэргэжил эзэмшжээ. Амьдралд ч, улс төрд ч Харвардын профессор Н.Грегори Мэнкьюгийн онолыг тулгуур болгодог гэдгээ тэрбээр нуудаггүй. Тэднийх хүү, охин хоёртой. Хүү нь Бээжингийн их сургуулиа төгссөн бөгөөд эдүгээ “Сентоза” компаниа удирдаж буй. Бага охин нь дунд сургуулийн сурагч.

СҮХБААТАР ДҮҮРЭГ: Х.БОЛОРМАА

Гадна төрхөөсөө ч хэлсэндээ хүрдэг шинж нь илт харагддаг түүнийг Ардчилсан намын өнгө төрх болж яваа хатагтай нарыг нэг хэмээн тодорхойлж болно. Өөрөө ч тийм нэг гүжирмэг, шулуун зантай нэгэн юм билээ. Улс төрд, дүүргийнхээ хөгжил цэцэглэлтийн төлөө хамтдаа зүтгэсэн журмын нөхөд нь Х.Болормааг алсын замд ханилсан байхад алзахгүй хэмээн магтах нь бий. Үүнийгээ ч орон нутгийн сонгуулиар намдаа болон журмын нөхөддөө харуулаад авсан. Ялагдал хүлээн бачимдаж буй цаг үед орон нутгийн сонгуулиар намдаа нэг суудал чирээд ирнэ гэдэг гавьяа байлгүй яах билээ. Х.Болормаа ажлаа хүлээж аваад удаагүй ч ажлын туршлагын хувьд бусад шиг дүүрэгтэйгээ танилцах, ажлаа юунаас эхэлбэл оновчтой хэмээн тархиа барихын зовлонг эдлээгүй. Өмнө нь дөрвөн жил Засаг даргын орлогчоор ажилласан төрийн төлөөлөгчийн хувьд хийж гүйцэгээгүй ажлаа шууд л барьж авсан байж таарна. Ер нь бол Сүхбаатар дүүрэг ажил үйлс, бүтээн байгуулалтаараа нийслэлийн зургаан дүүргийг манлайлсаар ирсэн билээ. Эдүгээ өөр намын бодлогод өөрийн мөрийн хөтөлбөр энэ тэрээ нийцүүлэх гэж ухаан зарж яваа байж мэднэ. Гэхдээ тэр чадна. Шулуухан хэлэхэд, 140 мянган өрхийнхөө ахуй амьдрал нь ямар түвшинд явааг, хэнд ямар тусламж үйлчилгээ хэрэгтэйг , хэн улс, дүүргийнхээ нэрийг дуурсгаж явааг Болормаа дарга андахгүй. Тэр ч утгаараа мань хүн “ Монгол Улсын нийслэлийн өнгө төрх нь, үүд нь болсон дүүрэг бол сүхбаатар. Бид эмх цэгцтэй, цэвэр цэмцгэр, эко дүүрэг болгохын төлөө хичээн ажиллах болно.

Иргэдээ дээдэлж, хувийн хэвшлээ дэмжиж ажиллах нь миний, бидний үүрэг.Тэгээд ч дүүргийн маань хүн ам жилээс жилд өсч, шинээр сүндэрлэх барилга байшин өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Тиймээс зохион байгуулалтыг чухалчилна” хэмээсэн нь олон үггүйгээр зорилго, төлөвлөгөө ойлгуулсан хэрэг. Нөгөөтэйгүүр, Засаг дарга Х.Болормаа иргэд хүлээж авах өдрийг зөвхөн тэдэндээ зориулдаг нь сүхбаатарчуудад ихээхэн таалагдах болсон байна. Өчигдрийн байдлаар 235 иргэнийг хүлээн авч уулзан 114 иргэний асуудлыг газар дээр нь шийдсэн байх жишээний. Энэ бол бага биш үзүүлэлт. Хагас, бүтэн сайныг тэрбээр Засаг даргын хувьд хороодын үйл ажиллагаатай танилцах хамгийн таатай боломжийн өдөр гэж үздэг юм билээ. Ийм нэг дайчин бүсгүй Сүхбаатар хэмээх их айлын голомтыг сахиж яваа. Ингээд түүнтэй Сүхбаатар дүүргийн хөгжлийн талаар “Монгол Улсын хөгжлийн гол зангилаа гэж би хувьдаа боддог. Та надтай санал нийлэх үү? хэмээн яриа өргүүлэхэд “Тантай санал нийлнэ. Нийслэлийн хөгжлийг энэ л өнцгөөс харж байгаа. Гэхдээ хөгжил судалгаагүйгээр явахгүй шүү дээ. Сүхбаатар дүүргээс төрсөн гэж онцолж, хэлтийлгүй эрдэмтэн мэргэдийнхээ үгийг сонсч, санаа оноогоо уралдуулж байгаад дүүргийнхээ хөгжлийн гарцыг бид тодорхойлсон. Бидний зорилго бол ахмад настнууд нь амар амгалан, залуус нь ажилтай, орлоготой, үр хойч нь эрдэм боловсролтой, улс нь эдийн засгийн чадавхитай байх явдал. Энэ бүхэн цогцолсон байхад аандаа хөгжилд хүрнэ. Тэгээд ч Монгол орон өөрийн онцлогтой. Тэр онцлогоо хөгжлийн бодлогод ямар байдлаар тусгаж өгөхөөс улсын хөгжлийн хурд шалтгаална.

-Та бизнесмен хүн. Тиймээс гэр хорооллын иргэдэд ямар боломж байгааг ажиглаж, судалж явдаг нь мэдээж. Ямар боломжууд харагдаж байна?

-Би аливаа зүйлийг жижгээр харах дургүй. Жижиг сэтгэвэл жижиг л амжилт ирнэ. Том сэтгэж, том харах хэрэгтэй. Жишээнь, монголчуудэлхийн брэнд бүтээгдэхүүнүүдийг үлдвэрлэдэг үйлдвэрүүдээс хоёр, гурвыг ч болов оруулж ирэхийн төлөө ажилламаар байгаа юм. Хууль, эрх зүйн орчин дээр нь хууль боловсруулагчид анхаарч, татварын таатай нөхцлийг тэдэнд санал болгоход л тэд гүйгээд орно шүү дээ. Миний хувьд санаж, сэдэж яваа бүхнээ ажил хэрэг болгохын төлөө зүтгэдэг дээ. Манай Сүхбаатар дүүргийн иргэдийн хувьд хашаа хашаандаа жижиг өрхийн аж ахуй эрхлэх бус үйл ажиллагааныхаа чиглэлээр нэгдэж нийлээд нэг хэсэг нь дан лууван, нөгөө нь байцаа, гурав дахь нь сонгино тариалж түүгээрээ дүүргийн иргэдийн хэрэгцээг хангаж болно. Монгол орны хөрсөнд ургасан лууван яаж ч бодсон импортын луувангаас аль ч талаараа илүү шүү дээ. Завханы улаан сармис гэж байдаг. Хятадууд манайхаас хэдэн арван кг-аар нь авч явдаг. Ааг, амт сайтай сармис. Түүнийг бас ургуулж болно. Хүнсний хамгийн аюулгүй бүтээгдэхүүн зөвхөн манайд л байдаг. Үүнийг мэддэг хятадууд Улаанбаатараас гурил хүртэл зөөнө гээч. Энэ бүхэн алдаж болохгүй бизнес. Тиймээс ХАА, газар тариалангийн салбарыг дэмжиж ажиллах болно” гэж хариулсан нь надад ч нэгийг бодогдуулж амжсан. Харин энд сонин болгож, түүнийг улстөрчийн хувьд хэн бэ гэдгийг энд өгүүлэхэд гэмгүй болов уу. Монгол оронд ардчиллын салхи сэвэлзсэн он жилүүдэд оюутан байсан тэрбээр болж буй үйл явдлыг эхэндээ залуу хүний сониуч зангаар очиж хардаг байснаа аандаа хэлж буй үг, баримталж буй бодлого нь чихний үзүүрт сул өнгөрөх дэмий зүйл биш санагдаад явчихсан гэдэг. Ингэж л ардчиллыг, улс төрийг дотоод сэтгэлдээ дэмжиж эхэлсэн гэнэ лээ.

MINFO.
Тал нутгийн цахим мэдээлэл

ЧУХАЛ ХҮН

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Д.Мягмарсүрэн:

Н.БАТЗАЯА

Дахин давтагдашгүй байгалийн нэгэн гайхамшиг болох сувд гэгч эрдэнэ их далайн ёроолд эгэл, даруухан нуугдан оршдог. Харин хүмүүс түүнийг нээн, түүнд хүрч, гайхамшигт үзэсгэлэн гоог нь магтан шагшдаг. Цаг хугацаа өнгөрсөн хэдий ч хэзээ ч хуучирдаггүй Улсын Драмын Эрдмийн театрын нэгэн сувд Жижиг хэрэглэлийн эрхлэгч Д.Мягмарсүрэнг энэ удаагийн "Чухал хүн" буландаа урьж ярилцаа. Тэрбээр, Улсын Драмын Эрдмийн театрын тайзны ард чимээгүйхэн, эгэл даруухнаар эрхэлсэн ажлаа хариуцлагатайгаар 50 гаруй жил хийж байгаа юм. Мөн энэ жил театрынхаа 85 жилийн ойгоор 35 жилийн турш арын албаныханы дунд тасарсан Урлагийн гавьяат зүтгэлтэн хэмээх цолыг театртаа авчраад буй.

ТЕАТР НАМАЙГ ХҮМҮҮЖҮҮЛЖ,

-Юуны өмнө танд Урлагийн гавьяат зүтгэлтэн хэмээх эрхэм шагнал хүртсэнд баяр хүргэе. Одоо ямар жүжиг дээр ажиллаж байна вэ. Энэ талаар ярилцлагаа эхлэх үү?

-Баярлалаа. Манай театрын хамт олон БСШУСЯ-ны "Хүүхдэд зориулсан уран бүтээлийн" төслийн уралдаанд шалгарсан Я.Баяраа, Б.Хишигзаяа нарын Монгол ардын үлгэр "Царцаа Намжил"-аас сэдэвлэн бичсэн зохиолыг тайзны бүтээл болгохоор ажиллаж байгаа юм. Би одоогийн байдлаар энэхүү жүжгийн жижиг хэрэглэл дээр ажиллаж байна. Жүжиг маань Улсын драмын эрдмийн театрын тайзнаа хоёрдугаар сарын 5-наас эхлэн тоглогдож, хүүхэд, багачуудын хүртээл болно. Ер нь жүжгийн тайзны бэлтгэл ажлууд бэлэн болсон. Гэрэл, хөгжим, жижиг хэрэгслүүд гэх мэтчилэн тайз хяналтын бэлтгэл ажил бүрэн хангагдсан. Энэ жүжигт манай шилдэг залуучууд тоглож байгаа учраас их сайхан болно гэдэгт итгэлтай байна.

-Монголын урлагийн их танхим гэгддэг Улсын Драмын Эрдмийн театрт 47 дахь жилдээ ажиллаж байгаа гэсэн. Анх энэ их айлын нэг гишүүн болон ажиллаж байсан дурсамжаасаа хуваалцахгүй юу?

-Би үйлдвэр комбинатын 18 дугаар сургуульд аравдугаар ангиа төгссөн. Биднийг бага залуу байхад "Илгээлтийн эзэд" гэж их сайхан арга хэмжээ болдог байлаа. Би бусад залуучуудын л адил Монголын хувьсгалт залуучуудын байгууллагаас илгээлт авч, гутлын 133 дугаар үйлдвэрт гутлын түрий өнгөлөх ажлын байранд томилогдсон юм. Тэнд би зургаан жил ажиллаад гарсан. Намайг үйлдвэрийн удирдлагууд гаргая гэсэн юм биш л дээ. Гутлын үйлдвэрт ажиллаж байхдаа Эвлэлийн хорооны тэргүүний ажилтан залуу алтан медаль, Засгийн газрын хөдөлмөрийн хүндэт медаль авч, сайн ажилчдынх нь тоонд ордог байсан. Гутлын үйлдвэрийн удирдлагууд ч намайг ажлаасаа гарна гэхэд "Илгээлтийн хүүхэд, сайн ажилтан" гээд дурамжхан байсан. Гэхдээ тухайн үед манай нөхөр ЗХУ-руу сурахаар явсан юм. Тэр үед нөхрийн маань ахынх нь эхнэр "Чи ганцаараа хоёр, гурван өдөр шөнийн ээлжинд ажиллаад яах вэ. Би чамайг нэг насаараа ажиллах сайхан газарт ажилд оруулж өгье. Чамайг театрт оруулна" гээд 1970 оны аравдугаар сард намайг энэ урлагийн сүмд оруулж өгч байлаа. Тэр үеэс л миний амьдралд театр гэх орон зай маш том байр суурийг эзэлж эхэлсэн дээ. Миний ханийн ахынх нь эхнэр 1942 онд бүтээгдсэн Сүхбаатар киноны Янжмаагийн дүрд тоглосон Ө.Рэнчинноров гэж сайхан эмэгтэй байсан. Одоо бурхан болсон л доо. Өдийд амьд сэрүүн байсан бол намайг энэ зэрэгтэй яваач хараад баярлах байсан байх. Тэр хүн миний зам мөрийг засч, тэгшилж явдаг ч юм болов уу гэж боддог юм. Яагаад гэвэл би тэр хүний ачаар л театр гэх айлтай танилцаж, ажил амьдрал, залуу насаа зориулсан. Тиймээс ч урмыг нь хугалахгүй ажиллах юмсан гэж үргэлж дотроо боддог байлаа. Миний тэр хүсэл биеллээ. Театрынхаа хамт олонд үргэлж баярлаж, тэд нараараа бахархаж явдаг.

-Аливаа зүйл гэдэг үргэлж багаас эхэлдэг. Залуу жүжигчид ч анх ажилд орохдоо туслах жүжигчнээс эхлээд үзэгчдийн сэтгэл зүрхэнд үүрд мөнхрөх хүртлээ дэвшин дээшилж байдаг. Та анх ажилд орохдоо шууд жижиг хэрэглэл хариуцаж байв уу?

-Би анх Драмын театрт заалны зохион байгуулагчийн албан тушаалд ажилд орж байлаа. Заалны зохион байгуулагч жүжиг үзэхээр ирсэн үйлчлүүлэгчдийн суудлыг нь зааж өгдөг. Мөн үзвэр, үйлчилгээ болон үйлчлэгч нарыг хариуцан ажилладаг юм. Би заалны зохион байгуулагчаар хоёр жил гаруй ажиллаж байгаад эрэгтэй хувцасны туслах ажилтнаар дөрвөн сар ажилласан. Манай эрэгтэй хувцасны эрхлэгч Цэрэнханд гэж их сайхан эгч зогсдог байж билээ. Тэр эгчийнхээ туслах ажилтныг хийж, тэндээс олон зүйлийг сурч мэдсэн дээ. Тэгж байтал 1973 оны сүүлээр даргын тушаал гарч, жижиг хэрэглэл хариуцан ажиллаж эхэлсэн. Тэр цагаас хойш тасралтгүй 44 жил театрын жүжгийн жижиг хэрэглэл хариуцан ажиллаж байна.

-Театрын арын алба ч гэсэн урлагийн төлөө зүтгэж явна гэсэн үг. Өмнө нь та урлагийн хүн болъё гэж бодож байсан уу. Анх театрт ажилд ороод тайзан дээрээс л харж байсан уран бүтээлчид, жүжигчидтэй хамтарч ажиллахад ямар санагдаж байсан бэ?

-Анх театр надад үлгэрийн ертөнц шиг л санагдаж байсан. Ажлаа хийгээд явж байхад нэг буланд хүн яриад зогсож байх шиг, энд ч нэг нь яриад л зогсож байна. Надтай яриад ч байгаа юм шиг санагдаад хааяа "аан" гээд л эргээд харчихна. Манай жүжигчид маань үргэлж л оногдсон дүрээ бэлдэж, өөрийгөө хурцалж байдаг юм л даа. Тэрийг нь анх би мэдэхгүй надтай яриад байна гэж ойлгодог. Яах вэ, Ө.Рэнчинноров эгч намайг кино драмын ангид шалгалт өгөөд үз гэж зөвлөдөг байсан. Өөрөө Багшийн дээдийн кино драмын ангид багшилдаг. Тэгээд л "Мягмарсүрэн чи намайг байгаа дээр кино драмын ангид шалгалт өгөөд үз" гэж надад хэлдэг. Тухайн үед би "Өө надад урлагийн А ч байхгүй" л гэнэ. Тэгэхээр өөдөөс "Урлагийн ангид сурсан бол заавал жүжигчин хийх албагүй шүү дээ. Утга зохиолын эрхлэгч, туслах найруулагч гээд олон төрлийн мэргэжлээс сонгож болно" гэдэг байсан. Тэр үед "Би урлагийн сургуульд сурч чадахгүй. Гэхдээ би энэ театраасаа гарахгүй" гэж л эгчдээ хэлсэн дээ. Манай гэр ч театртай их ойрхон байсан болохоор надад их амар байсан л даа. Яагаад гэвэл бидний ажил цаг, наргүй шүү дээ. Өглөө ажилдаа ирээд шөнө гэртээ харих үе байна. Заримдаа бүр өглөө эрт ирэх үе байдаг. Тэр үед хүүхдүүд маань ч, дүү нар маань ч жаахан байсан. Одоо эргээд санахад ээж минь амьд сэрүүн байсан болохоор л надад их дэмтэй байж дээ гэж их бодогддог юм. Ер нь урлагийн хүн цаг, наргүй л ажилладаг болохоос дандаа шижигнэсэн сайхан залуучуудтай ажилладаг учраас үргэлж тэд нараасаа эрч хүч, энерги авдаг. Тиймээс урлагийн хүн үргэлж хийж, бүтээхийн хүслээр дүүрэн явдаг байх.

-Театрт ирсэн үзэгчид зөвхөн тайзан дээр өрнөж буй жүжгийн амьдралыг л харж, сэтгэлийн таашаал авдаг. Харин тайзны ард ямар амьдрал буцалж байгааг, жүжигчдийн өмссөн хувцас, сууж буй сандал, ууж байгаа аяга ус ямар үнэ цэнээр бүтэж, тэр жүжиг өөрт нь хүрч байгааг мэддэггүй. Ер нь жүжиг тоглогдож байхад тайзны ард ямар амьдрал, үйл явдал өрнөж байдаг юм бэ?

-Театр гэдэг нэг айлтай л адилхан. Ер нь театр бол нийлмэл урлаг шүү дээ. Найруулагч, жүжигчин, зураачаас гадна арын алба, үйлчилгээ, цэвэрлэгээ, нягтлан, санхүү, захиргаа, гэрэл, техник, шуум, хувцас, парик, дархан, мужаан гээд энэ бүгд нийлж нэгэн цогц болж байж сая театр бий болдог юм. Хэдий хүмүүсийн ард чимээгүйхэн ажлаа хийгээд, жижиг хэрэглэлээ зөөгөөд явж байгаа ч гэсэн театрт элэгтэй, хайртай, ойлгодог хүн л энэ дотор ажиллана. Харин театрыг ойлгодоггүй хүн бол ажиллаж чадахгүй л дээ. Нэгдүгээрт, цаг, наргүй ажилладаг учраас цагт баригдана. Хоёрдугаарт, төсвийн байгууллага учраас цалин тийм ч их биш. Ер нь харж байхад театрт ажиллаж байгаа хүмүүс нэг тийм муу явдаггүй юм. Муухай ч байдаггүй. Тэр бүү хэл муу зүйл рүү ч уруу татагддаггүй. Үргэлж хүмүүсийг зөв зүгт залж, чиглүүлж байдаг ариун сүм болсон газар. Мэдээж, театр хамтын урлаг учраас арын албаны хүмүүс жүжигт хэрэглэгдэх зүйлсээ бүрэн хариуцаж, жүжигчид нь дүрээ сайн гаргаж нэгэн цогц болон ажиллах ёстой. Би л гэхэд тухайн жүжигт хэрэглэгдэх жижиг хэрэглэлүүдээ жүжигчиндээ хариуцуулж өгч, үзэгдэл болгон дээр хянаж байх ёстой. Хүн бүр эрхэлсэн ажилдаа чин сэтгэлээсээ хариуцлагатай хандахыг шаарддаг. Гэрлийн техникчид гэрлээ цаг тухайд нь өгнө. Дууны инженерүүд мөн л адил ажиллана. Жүжиг эхлэхэд зааланд ямар халуун дулаан, эрч хүчтэй амьдрал буцалж байна тэр бүхэн л тайзны ард үргэлжилж л байгаа. Хүн бүр дор бүрнээ жүжиг дуустал өөрийн хариуцсан ажлаа ягштал хийдэг.

-Театр айлтай адилхан гэж та хэллээ. Таны өрөөнд айлд хэрэгтэй бүх зүйлүүд байна. Шүдэнзнээс авахуулаад ширээ, сандал, хүүхдийн тоглоом, чихэр, жимс гээд байхгүй юм алга шиг байна?

-Тийм. Надад барааг байдаггүй зүйл байхгүй дээ. Чи миний өрөөг хар л даа. Надад буу, зэвсэг, бурхан тахил, ор, дэр, ширээ, сандал гээд бүгд л бий. Наад зах нь гэхэд шүдэнз, лаа хүртэл байна. Хэрвээ жүжигт хоол, цай хэрэгтэй бол хоолыг нь хийгээд, махыг нь чанах үе гарна. Тэр жүжигт хэрэглэгдэж байгаа бүх л жижиг хэрэглэлүүд миний гараар дамжиж хэрэлэгдэж байгаа.

-Жүжгийн зохиол янз бүрийн цаг хугацаанд өрнөдөг болохоор тухайн үеийн хүмүүсийн ахуйн хэрэглээний зүйлс их шаардагддаг байх нь. Тэгж байж жүжиг илүү үнэмшилтэй, хүмүүсийн сэтгэлд ойр болно. Заримдаа жүжигт шаардлагатай байгаа хэрэглэлүүд олдохгүй байх тохиолдол байдаг уу?

-Олдоно л доо. Зарим нэгийг нь энэ тэндээс гуйна. Юун түрүүнд үйлдвэр үйлдвэр ангийнхаа даргад хэлнэ. Тухайн жүжгийн зохиол, цаг үеэс хамаараад янз бүрийн жижиг хэрэглэл олох хэрэгтэй болдог. Жишээлбэл, япон жүжгийн нэг үзэгдэлд шүдэнз хэрэгтэй болбол монгол шүдэнз өгч болохгүй шүү дээ. Ямар нэгэн аргаар олно. Одоо сүүлийн үед хуучны сонин олдохоо байсан. Ямарсайндаа хуучны сонин олдохгүй болохоор энд тэнд явж байхдаа 1957 оны "Үнэн" сонины нүүрэн хэсгийн тал байхад нь авч хадгалж байх вэ дээ. Архивд ч бараг байхгүй болжээ. Орчин үеийн жүжигт кофены аяга хэрэг болж байхад түүхэн жүжигт мөнгөн аяга хэрэг болно. Тэр болгоныг олно. 1990-ээд оны өмнө үед жижиг хэрэглэлийг ихэвчлэн бутивороор хийдэг байлаа. Тэр үед манай театрт УГЗ Д.Гүрдорж гуай ажиллаж байсан. Д.Гүрдорж гуай маань усан үзэм, алимыг лааны тосоор л хийчихдэг. Түүнийг нь тайзан дээр тавихад жинхэнэ юм шиг л их сайхан харагддаг байсан. Одоо ч мөнгө нь байвал гараад бэлэн юм авдчихдаг болж дээ.

-Хамгийн удаан он цагийг элээж байгаа ямар хэрэглэл байна вэ?

-Би театрт ажиллаад 47 жил болж байна. Намайг энд ажиллахаас өмнө Бөмбөгөр театр, Дуурийн театр байсан. Сүүлд тусдаа байгууллага болсон. Намайг ажиллахаас өмнө хэрэглэж байсан зүйлүүд ч бий. Орчин үеийн жүжигт иэхвчлэн тавилга хэрэг болж байна. Склад маань жаахан багадаад л байгаа. Олон жил болж байгаа гэвэл телефон утаснууд байна. анх ямар байснаасаа эхлээд л бий. Буу, бурхан тахил гээд дурдвал олон хэрэглэл байгаа. Харахад хүмүүст хэрэггүй юм шиг хэрнээ энэ театрт маш их хэрэгтэй зүйлүүд л миний өрөөнд байдаг. Архины шил, гоё тамхины хайрцаг гээд бүгд л энэ театр хэрэгтэй.

-Та сая УГЗ Д.Гүрдорж гуайг лааны тосоор алим, өгөрций, усан үзэм хийж байсан. Одоо мөнгө нь байвал гараад авчихдаг болсон гэлээ. Одоо харахад, тэр үеийн жижиг хэрэглэлүүд илүү их үнэ цэнээр бүтдэг байсан юм шиг байна?

-Тэгэлгүй яах вэ. Тэр бүтээлийг хийхийн тулд хүнээс маш их хүч, хөдөлмөр бас сэтгэл шаардагдана. УГЗ Д.Гүрдорж төрийн тэргүүнүүдийн хөргийг хонины нэхийн дээр хайчилдаг байсан. Бүтэн хонины гулууз махыг хүртэл театрт хийж өгсөн. Тийм их хөдөлмөрч, авьяастай хүн. Би саяхан 100 жилийнх нь ойгоор хийсэн хэрэглэлүүдээр нь өрөөндөө үзэсгэлэн гаргасан. Тийм мундаг хүний бүтээлийг хамаагүй гаргаж өгмөөргүй л байгаа юм. Он удаан жил хэрэглэгдэх учраас бас олон ашиглаад баймааргүй. Яагаад гэвэл тэр хүн шиг давтаж хийх хүн байхгүй шүү дээ. Тэгээд би зураач,уран барималчны мэргэжлээр төгч ирж байгаа хүүхдүүдэд "Та нар ийм сайхан бүтээл хий. Ийм бүтээл хийгээд театрт өгөөч ээ" гэдэг санал тавиад л байгаа. Тэгээд бид чинь хуучин эд, хэрэглэлээ хайрлаж, гамнах хэрэгтэй.

-Орчин цагийн хүүхэд, залуусын талаархи шүүмжлэлт хандлага нийгэмд байдаг. Та тетарт 50 гаруй жил ажиллаж байгаа хүний хувьд салбарынхаа хэд хэдэн үеийн залуусын төлөөлөлтэй хамт ажиллаж байна. Энэ тал дээр бодож явдаг зүйл байгаа байх. Сүүлийн үеийн залуусын ур чадвар гэхээс илүү ажилдаа чин сэтгэлээсээ хандах хандлага нь ямар байна вэ?

-Би зарим зүйл дээр их эмзэглэж явдаг. Юу гэхээр ялангуяа 1996 оноос хойшхи үеийн залуус хүний мөс, мөн чанараар муудсан юм уу даа гэсэн бодол надад төрдөг. Манай театрт зураач, уран барималчаар ирж байгаа 1996 оноос өмнөх үеийн залуусыг харахад ажилдаа их сэтгэлтэй байдаг. Яах вэ, хүний олон дотор янз бүрийн л хүмүүжилтэй, зан аштай хүмүүс бий. Гэхдээ нийтлэг хандлагыг ажиглахад тийм болсон шиг санагддаг. Тухайлбал, манай театрт зураач, барималч, туслах зураач мэргэжилтэй Түмэн-Өлзий гэж залуу бий. Тэр хүү бол аливаа ажлыг сэтгэлээрээ хийдэг. Нэг л удаа хүнээр хэлүүлнэ. Би нэг удаа тэр хүүхдээс юм гуйсан л бол бэлдээд тавьчихдаг. Дараа хийж өгье, энэ ажлыг хойшно тавьчихъя гэсэн зүйл огт байдаггүй. Зарим залуус жаахан хүнийг хүндлэх, хүнд туслах хүн байхын учир болсон ариун сайхан, гэгээлэг зан, чанаруудаа мартаж байна. Энэ тал дээр үнэхээр дулимаг байгаа нь ажиглагддаг. Заавал хоёр, гурван удаа хэлүүлж, хүнийг уурлуулж, хүнээр загнуулж байж юм хийнэ гэж байхгүй шүү дээ. Ер нь театр өөрөө хүнийг биеэ авч явах соёлоос эхлээд л сургадаг. Нэг их ажил хийж байгаагүй хүүхдүүд орж ирснээ театртаа хайртай болчихсон, гарах гэж байснаа больчихсон залуучууд олон байдаг. Театрт үзэх, харах, суралцах зүйлс олон байна.

-Намайг оюутан байхад их сургуулийн багш нар театрт драмын жүжиг үз, тэндээс та нар наад захын соёлыг сурна гэж хэлдэг байсан. Үнэхээр театрт орж ирэхэд бие хүртэл цэгцэрдэг шүү дээ. Гадуур хувцастайгаа хүртэл үзвэрийн танхим руу орохгүй, заавал өлгүүлж ордог. Энэ мэтчилэн театр өөрөө хүнийг ёс зүйд их сургадаг юм шиг санагддаг?

-Намайг 1970-аад оны үед угтагч хийж байхад хүмүүс их гоё хувцаслаж ирдэг байсан. Өвлийнхөө гутлыг тайлчихаад бүсгүйчүүд нь их гоё даашинз эсвэл юбка цагаан цамцны хослол, туфль, эрэгтэйчүүд нь костюм пиджакны хослол өмсдөг байлаа. Бүжиг, хүлээн авалтад орох гэж байгаа юм

ЧУХАЛ ХҮН

ХАРИУЦЛАГАД СУРГАСАН

шиг их гоёж ирцгээнэ. Одоо нийгмийн байдал, цаг үе ч өөр болсон юм шиг байна. Хамт олноороо л жүжгийн захиалга өгөөгүй бол тэгж их гоё хувцаслахаа больсон байна. Зарим нь бүр хааяа гадуур хувцастайгаа суугаа харагддаг. Яах вэ, заримдаа ч театр хүйтэн байхаар албаар ч хувцсаа тайлдаггүй байж магадгүй юм л даа. Гэхдээ гадуур хувцсаа өлгүүлж, сайхан хувцаслаж ирнэ гэдэг жүжигчид, театрын тайзын хүндлэхээс гадна тэр хүн өөрийгөө хүндэлж байгаагийн нэг шинж. Энэ бол соёл.

-Таны ажил, амьдралын он жилүүд жинхэнэ алтан үеийн жүжигчидтэй өнгөрсөн шүү дээ?

-Их сайхан сайхан хүмүүстэй хамт ажиллаж байсан даа. 1970-аад оныхон гэвэл АЖ Н.Сувд, АЖ П.Цэрэндагва гээд олон хүмүүс бий. Одоо ч хамт ажиллаж байна. Тухайн үед Цэрэндагва манай театрт аравдугаар ангий төгсөөд ирсэн. Дараа нь Кино драмын дээдэд суралцсан. Би бидний сэтгэл зүрхэнд хоногшсон Дамдинсүрэн гуай, Ичинхорлоо, Хандсүрэн, Байдий, Лувсанжамц, Мижиддорж гуай гээд одоо үеийн залуусын хэллэгээр "од" гэдэг шиг тэр сайхан одуудтай хамт ажиллаж байлаа. Тэд нар маань ч биднийг их хайрладаг байж. "Өө энэ арын албаны тайзны юм. Яахав" гэж ерөөсөө хэлдэггүй. Бид нар ч тэд нарыг хүндлээд, айж, эмээнэ. Бидний үед удаан хугацаагаар хөдөө бригадаар их явдаг байсан. 45, 60 хоног явна. 30 хоног бол юу ч биш. Ёстой тоглоом л байсан. Аймаг, орон нутаг, сумуудаар хүртэл явна. Ер нь гэр, орноосоо хол хөдөө бригадаар явж байхад л хүмүүсийн зан чанар их танигддаг. Манай Цэрэндулам, Ичинхорлоо, Хандсүрэн гуай эд нар "Нөгөө хэд маань ачаагаа даруулчихаад даараад ирнэ" гээд хар цай чаначихсан биднийг хүлээгээд сууж байж байдаг байсан. Тэр үед ямар ус буцалгагч гэж байх биш тавын хувин дотор дүрдэг пелетька хийгээд л цайгаа чанана. Би хөдөө, орон нутгийн томилолтод ихэвчлэн билетийн кассаар явдаг байсан. МУГЖ Б.Пүрвээ, АЖ Ж.Лхамхүү, АЖ Г.Мягмарнаран гурав бригад ахалж явдаг. Тэгээд намайг билетийн кассаар явна шүү гэдэг байсан. Ямар сайндаа л АЖ Ж.Лхамхүү "Чи л наадахаа мэддэг шүү дээ" гэдэг байж билээ. Бид зүүн, баруун аймгууд руу хоёр хуваагдаж хүртэл бригадаар явна. Ер нь бүх аймаг, сумыг гүйцээсэн дээ. Зарим аймагт нь 4-5 удаа ч очсон байх. Одоо бригад аймгийн төвүүдээр 10 хоног л яваад ирдэг болсон байна.

-Ер нь ээж, аав, эмээ, өвөө нарын яриаг сонсож байхад тэдний хүүхэд нас их нандин дурсамжтай өнгөрсөн юм шиг санагддаг. Одоо үеийн хүүхдүүд телевизийн олон ангит кино, гар утас, компьютерны ард л бага насаа өнгөрөөж байна?

-Би Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд төрсөн. Намайг гурван сартай байхад манайх Улаанбаатарт шилжиж ирсэн. Бараг Улаанбаатарын унаган иргэн дээ. Миний ээж Улаан-Үд хэжэнгийн бурайд, аав Сэлэнгэ аймгийнх. Ээж маань нэг насаараа төв түүхий эдийн бааз гэдэгт л ажиллаж байгаад тэтгэвэртээ гарсан. Харин аав маань насаараа намын дарга, суртал ухуулагч хийсэн. Сүүлд Дархан шарын голын намын хороонд ажиллаж байгаад тэтгэвэртээ суусан хүн байдаг. Манайх 12 хүүхэдтэй их өнөр өтгөн айл л даа. Би зургаа дахь хүүхэд нь болж мэндэлсэн юм. Ер нь би арван жилд байхдаа их хөдөлгөөнтэй охин байсан. Одоо хэлэхэд хүн итгэхгүй байх. Гэхдээ би жаахан ч болтугай эрээн даавуугаар палаж хийлгүүлж, буцааж авна. Гол дүрийн жүжигчдийнхээ хэрэглэлийг хүртэл өрөөнд оруулж өгдөг. Жүжигт шаардлагатай хоол унд, уух юмыг нь бэлтгэнэ. Тэр идэх зүйлсийг хамаагүй ил тавьж болохгүй. Яагаад гэвэл хүмүүс нэг стакантай ус байхад тамхиа хаячихдаг ч юм уу эсвэл уучихаж болно шүү дээ. Тиймээс маш сайн харж байх ёстой. Ялангуяа ууж, иддэг зүйлд нь маш нарийн байх ёстой. Мөн үзэгдэл, үзэгдлээр нь хэрэглэгдэх жижиг хэрэгслүүдээ засаад бэлдчихдэг. Аяга байх уу, зурагтын удирдлага байх уу. Тэр бүгдийг бэлтгэдэг. Жижиг хэрэглэл хариуцсан хүн тийм зүйл дээрээ л нарийн ажиллана. Би жүжигчиддээ "За энэ юм чинь энэ байна шүү. Би энд тавилаа шүү. Юм аа хараарай, шалгаарай" гэж байнга захидаг. Би тэгж л ажилладаг. Тэр хүн сандраад юмаа мартсан өмсөж үзээгүй. Яагаад гэвэл би эрэгтэй хүүхэд шиг эршүүд байсан л даа. Үргэлж хөвгүүдтэй гадаа тэвэг өшиглөж тоглодог. Эсвэл надад шаариг гэж хав нохой байсан юм. Тэрэнтэйгээ тоглоод өдрийг барчихдаг. Нохойтой их тоглохоор хамаг хувцас, нооройгоодурагдчихна. Тэгэхээр л аав, ээж хоёр палаж нэг их хийж өгье гэж боддоггүй байсан байх л даа. Тэр хавийн хүмүүс аавын минь нэрийг дурсаж байгаад л "Эдний шар охин ёстой олигтой хүн болохгүй ээ" гэж ярьцгаадаг байсан. Сүүлд гутлын үйлдвэрт ажиллаж байхдаа гар бөмбөг их тоглодог байлаа. Миний хүүхэд нас хав нохой, тэвэгний хооронд л өнгөрсөн дөө. Гэхдээ их сайхан зугаатай шүү. Бидний үеийн хүүхдүүд хоорондоо их тоглодог байсан. Магадгүй энэ нь хүний амьдралд хэзээ ч мартагдашгүй сайхан дурсамжийг үлдээдэг байх. Одоо үеийн хүүхдүүд гар утаснаас салахгүй л байгаа харагддаг. Утсан дээр тоглоом тоглоод л сууж байх юм байна шүү дээ.

-Таны ажил яг хэзээнээс эхэлдэг вэ. Зарим хүмүүс ажил их оволзоод, түргэн шуурхай хөдлөөд ирэхээр хийж байгаа ажлаасаа сайхан мэдрэмжийг авдаг шүү дээ?

-Миний ажил жүжгийн хар зураг гараад л эхэлнэ. Жишээлбэл, "Царцаа намжил" жүжигт ямар жижиг хэрэглэлүүд хэрэгтэй байна. Ямар жүжигчинд аль хэрэглэлийг олж өгөх вэ гээд л ажил эхэлнэ дээ. Бид 11:00 цагт цуглаарай гэсэн бол 09:30 цагийн үед л ирдэг. Арын албаны ажилчид жүжигчдээсээ түрүүлээд хоёр цагийн өмнө ирж тухайн жүжигт шаардлагатай бүхий л зүйлээ хариуцлагатайгаар бэлтгэнэ. Би эрт ирсэн бол ардын жүжигчин, алдар цолтой хүмүүсийнхээ бүх жижиг хэрэглэлийг өрөөнд нь оруулж өгнө. Жүжиг дуусахаар байлаа гэхэд би өөрөө наашаа сандарч гүйхгүйн тулд л тэгж ажилладаг. Ер нь хоёр цагийн өмнө ирнэ гэдэг чинь бүх юм аа шалгаж, нягталж үз л гэсэн үг.

-Шаардлагатай нэг хэрэгсэл л байхгүй бол тэр жүжиг нурах магадлал тун өндөр байх нь. Таны ажил маш хариуцлага шаарддаг юм байна?

-Тийм. Миний ажил хүнээс их хариуцлагыг шаарддаг. Хариуцлагатай байхаас ч өөр арга байхгүй. Би нэг удаа УГЗ Б.Баатар найруулагчийн "Гургалдайн дуут шөнө" шөнө жүжигт их айхтар том алдаа гаргахаа дөхсөн. Тэр өдөр би нэлээн эрт ирсэн. Өглөө ирээд жүжигчдийн жижиг хэрэглэлийг бэлдээд өрөө, өрөөнд оруулж өгчихөөд, жүжиг эхэллээ. Би тоглолттой үед тайзны хажууд сандал дээр суучихдаг юм. Гэтэл жүжиг эхлээд бараг дундаа орох гэж байхад нэг зүйл дутуу юм шиг санагдаад болдоггүй. Хараад байсан чинь би генералын өрөөнд тавих ёстой том хар телефон утсыг мартчихсан байсан. Тэгээд өрөө рүүгээ гүйж нөгөө утсаа аваад ирсэн яг дараагийн үзэгдэл дээр нь генерал өрөөндөө утсаар ярьдаг хэсэг нь гарах болчихсон байсан. Тэр үед тайзны хажууд манай театрт ажиллаж байсан Сүхээ гэж жүжигчин зогсож байна. Тэрэнд "Чи одоо гарах гэж байна уу. Эгч нь энэ том утсыг тавихаа мартчихаж. Дараагийн үзэгдэл дээр Мягмарнаран утсаар ярих юм" гэсэн чинь Сүхээ "Генералд болох уу. Аппарат засчихлаа" гэж хэлээд оруулж өгч байсан. Тэр үед Мягмарнаран генералын дүрд тоглож байсан л даа. Гэхдээ тэр утсыг байхгүй байгааг Мягмарнаран ч мэдээгүй. Хэрвээ тэгж олж хараагүй бол Мягмарнаран утсаар ярьж чадахгүй, тэр жүжигчний дараа дараагийн үзэгдэл бүгд нурна шүү дээ. Тийм л аюултай. Би тэгж нэг амьдралдаа айхтар том алдаж зогсдог. Учир нь нэг нь гацвал нөгөөдөхөөр нь буудна гэж. Ямар үгний дараа буудах уу тэрийг маш анхаараалтай сонсож зогсоно. Би түрүүлээд эсвэл хэзээ хойно нь буудчихвал тэр жүжиг бас л амжилтгүй л болно. Заримдаа би ажлаа их зүүдэлнэ. Нэг хэрэглэл маань нүдэнд харагдахгүй байвал яасан юм бол, энэ жүжгэн дээр тийм зүйл дутах нь дээ гээд л зүүдэлчихдэг. Ер нь арын албаны ажил гэдэг их хариуцлагатай даа.

-Ер нь жүжиг дуусаных дараах үзэгчдийн алга ташилт арын албаныханд зориулагддаг байх нь. Таны хүүхдүүдээс урлагийн хүн байдаг уу?

-Би түрүүнд театр гэдэг нийлмэл урлаг гэж хэлсэн. Бид бүгд хамтарч ажиллаж байж нэг жүжгийг амжилттай тавина. Тэгэхээр үзэгчдийн алга ташилт арын албаныханд зориулагдалгүй яах вэ. Хэдийгээр арын албаныханд гэж нэр цохиж хэлэхгүй ч жүжиг амжилттай боллоо, бидэнд таалагдлаа л гэж алга ташиж байгаа шүү дээ. Тэр л хангалттай. Миний хүүхдүүд, ах, дүүгийн хүүхдүүд маань театрт ажилладаг. Манай эгчийн хүү Ганхуяг гэж залуу бий. Одоо театрт дууны найруулагч хийдэг. Миний том хүү Батсайхан театрт дууны техникчээр ажилладаг. Том хүүгийн маань хүү хөгжим бүжгийн коллежийн бүжгийн ангийг төсгөөд Улсын ардын дуу бүжгийн чуулгад хоёр жил бүжиглэж байгаа. Одоо араасаа дахиад хүн дагуулахгүй гэсэн чинь бас нэг нь урлагийн хүн болох гэж л байгаа юм шиг байна билээ. Би өөрөө их буянтай хүний ачаар энэ сайхан ариун сүмд насаараа ажиллаж байгаа. Ямар ч гэсэн намайг ийм сайхан газар оруулж өгсөн хүний нэрийг нь хугалахгүй байх юмсан, энэ театраас салахгүй гэж бодож л ажилласан. Сая тэтгэвэртээ гарах гэсэн "Болоогүй ээ. Та ганц, хоёр жилдээ ажиллаж байхгүй юу" л гэж байна лээ. Би 40 гаруй жил энэ тасгийг авч явж байгаа хүн. Би байгаа юм байгаагаараа л байх ёстой гэж боддог. Одоо жижиг хэрэглэлүүдийг сэлбэдэг байх хэрэгтэй. Хүнд цус сэлбэнэ гэж байдаг шүү дээ. Түүнтэй адилхан үргэлж сэлбэлж, хуучнаа хайрлаж, хамгаалж, арчилж явах ёстой юм. Тиймээс цаашид над шиг 40 гаруй жил аваад явахгүй юм гэхэд 10 жил энэ хэвээр нь аваад явчихаар хүнд энэ ажлыг үлдээх юмсан л гэж боддог.

-Нэгэн үе Монголын үзэгчид хошин урлаг руу шуурч, театрын урлаг орхигдсон. Харин сүүлийн үед залуучууд театрт жүжиг үзэхийг хүсдэг болсон байна. Хүмүүсийн энэ хандлага театрт ажиллаж байгаа хүмүүсийн хичээл зүтгэлтэй холбоотой болов уу гэж боддог юм. Та ер нь театрын урлагийн өнөөгийн хөгжлийг хэрхэн хардаг вэ. Дотор нь ажиллаж байгаа хүний хувьд?

-1990-ээд оны үед Монголд театрын урлаг уналтад орсон гэж хэлж болно. Хаалгаа барих дөхөж байсан. Тэр үед хошин урлагийн "Туйлшрал", "Х түц", "Өнгөт инээд" зэрэг продакшнууд гарч ирсэн. Тухайлбал, Н.Онон, И.Одончимэг, С.Өлзийхүү, Л.Дэмидбаатар, Н.Ариунболд эд нар чинь хамтраад л хошин урлагийн тоглолт зохион байгуулдаг байлаа. Харин хошин урлагийн үндэс суурийг Н.Цэвээнравдан,Ж.Дорлигжав, Д.Сосорбарам, Б.Цэрэнпагма нар тавьж, анхны тоглолтыг хийж байсан юм. Одоо манай театрын жүжгүүдийг үзэхгүй нь гэх зүйлгүй болсон. Өдий хэмжээнд хүрэх болсон нь Төрийн шагналт найруулагч Н.Наранбаатартай холбоотой болов уу гэж би боддог юм. Гэхдээ олон сайхан найруулагч нар бий л дээ. Эхлэлийг нь Н.Наранбаатар тавьсан байх. Найруулагч Н.Наранбаатар анх "Надаар тоглосон хайр" гэж жүжиг хийсэн юм. Анх хувийн жүжиг гарч ирсэн л дээ. Бид тухайн үед ажиллаагүй байсан болохоор оруулахгүй, ажилгүй бол гэртээ харь гэдэг байсан. Тэр жүжгийг тавьсан, оролцон тоглосон Н.Наранбаатар, Г.Эрдэнэбилэг, Г.Амгаланбаатар, С.Болд-Эрдэнэ, Д.Ганцэцэг залуучуудыг театрын урлагт их татсан даа. Сүүлийн үед "Гамлет", "Ромео Жульетть" гээд дандаа сайхан залуучууд тоглож байна. Би АЖ Б.Мөнхдорж найруулсан "Хунгийн дуу" жүжигт их дуртай. Энэ жүжигт манай гурван ардын жүжигчин тоглосон. Н.Сувд, Г.Мягмарнаран, П.Цэрэндагва гурав тоглосон. Энэ жүжгийг хүмүүс их үздэг. Ялангуяа Н.Наранбаатарын найруулсан жүжгийн тасалбарын кассаар 90 гаруй нь борлогдож байна. Өмнө нь театр тасалбараа албан байгууллагад шахдаг байсан бол одоо хүмүүс театрын билетийн кассаар ирж үйлчлүүлж байна. Ер нь Монголын театрын урлаг энэ хэмжээнд хүрсэн нь театрт сэтгэл зүрхээ зориулсан үе үеийн жүжигчид ажилчдын хичээл зүтгэлтэй л холбоотой. Хүн бүр ажлаа чин сэтгэлээсээ хийж байгаа учраас үзэгчдийг татаж байгаа юм.

> Би нэг удаа УГЗ Б.Баатар найруулагчийн "Гургалдайн дуут шөнө" шөнө жүжигт их айхтар том алдаа гаргахаа дөхсөн. Тэр өдөр би нэлээн эрт ирсэн. Өглөө ирээд жүжигчдийн жижиг хэрэглэлийг бэлдээд өрөө, өрөөнд оруулж өгчихөөд, жүжиг эхэллээ. Би тоглолттой үед тайзны хажууд сандал дээр суучихдаг юм. Гэтэл жүжиг эхлээд бараг дундаа орох гэж байхад нэг зүйл дутуу юм шиг санагдаад болдоггүй. Хараад байсан чинь би генералын өрөөнд тавих ёстой том хар телефон утсыг мартчихсан байсан. Тэгээд өрөө рүүгээ гүйж нөгөө утсаа аваад ирсэн яг дараагийн үзэгдэл дээр нь генерал өрөөндөө утсаар ярьдаг хэсэг нь гарах болчихсон байсан.

NO STRESS

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

“Үхрийн уралдаан”

Б.СУМЬЯА

Дэлхийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “Sony world photography awards-2014” наадмын спортын мэргэжлийн зургийн төрөлд өрсөлдөн шилдгээр шалгарсан бүтээлийг сонирхуулж байна. Энэ зургийг БНХАУ-ын хамгийн шилдэг 10 зурагчны нэг гэгддэг Ён Шенг Зенг авчээ. Тэрбээр Индонезийн Суматраа арлын Паданг гэх хотод жил бүр зохион байгуулагддаг уламжлалт үхрийн уралдааны үеэр энэхүү агшныг дурандаа буулгасан байна. Тус уралдаан бүр 400 жилийн түүхтэй ажээ. Ихэвчлэн цагаан будаа хураалтын дараа болдог бөгөөд нутгийн иргэд тэмцээнийг “Паку Жави” гэж нэрлэдэг байна. Будаа тариалалтын талбайд иргэд хэсэг хэсэг болж хуваагдан тус бүр хоёр үхрийг сонгон уралдаж, хөгжилддөг ажээ. Ингэхдээ багийн нэг эрэгтэй хоёр үхрийн баруун болон зүүн талд бэхлэсэн модноос барин залах зарчмаар бэрхшээл саадыг даван 20-30 метр зайд уралддаг байна. Тухайн хүнээс авхаалж самбаа хүч шаардсан эл спортын тэмцээн олон ч хүний анхаарлыг татдаг ажээ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -11
Шөнө -22

Нөгөөдөр
Өдөр -10
Шөнө -23

Өдрийн зурхай

ӨВЛИЙН АДАГ ЦАГААГЧИН ҮХЭР САР ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ЦАГААН БИЧ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.19-17.54
Үс засуулбал: Өнгө зүс сайжирна

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Андгай тангаргаас няцах, дайсныг ноцхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/ Баруун нүд татвал эд олох, баруун чих хангинавал айтшиг болох, зүүн чих жингэнэвэл жуулчин ирэх, хэрээ дуугарвал зочин ирэх, тагнай загатанал амгалан болох, бие татвал эцэг эх цочих, хөл татвал тэмцэл болно. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.

ДУУЛГАХ СОНИН

Цэрэгжлийн гимнастикийн АВАРГАА ШАЛГАРУУЛАВ

Их жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 124 жилийн ойн хүрээнд Зэвсэгт хүчний 2017 оны Цэрэгжлийн гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн Их жанжин Сүхбаатарын нэрэмжит ҮБХИС-ийн Биеийн тамир, спорт сургалтын төвд эхэллээ. Тэмцээний нээлтийн ажиллагаанд ЗХЖШ-ын Орлогч дарга, Бригадын генерал Ж.Бадамбазар, ҮБХИС-ийн захирал, Хошууч генерал Я.Чойжамц, ЗХЖШ-ын Сургалтын хэлтсийн дарга хурандаа Н.Гантулга, Биеийн тамир, спортын тасгийн дарга хурандаа Д.Цог-Эрдэнэ, Жанжин Д.Сүхбаатарын зээ охин хатагтай Т.Сүхжаргалмаа “Армийн генерал асан Батын Дорж” сангийн тэргүүн, зээ охин Б.Энхмаа болон бусад албаны хүмүүс оролцож, Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөн, хүндэтгэл үзүүллээ.

“Цэрэгжлийн гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг бөгөөд энэ талаар Биеийн тамир, спортын тасгийн дарга хурандаа Д.Цог-Эрдэнэ “Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн хувьд Их жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит цөөн байгууллагуудын нэг гэдэг утгаараа энэхүү тэмцээнийг зохион байгуулж байгаа нь нэр төрийн хэрэг юм. Д.Сүхбаатар жанжны хувьд цэрэгжлийн гимнастикт онц сайн хүн байсан учраас манай зэвсэгт хүчний алба хаагчдын хувьд бахархал болж явдаг. Тиймээс ч энэ хүний нэрэмжит “Цэрэгжлийн гимнастикийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг зохион байгуулсаар багагүй хугацааг үдсэн байна. Энэ жилийн хувьд 32 байгууллагын 190 гаруй тамирчин өргөн бүрэлдэхүүнээрээ оролцож байгаагаараа онцлог боллоо” хэмээсэн юм. Зэвсэгт хүчний 2017 оны “Цэрэгжлийн гимнастикийн аварга шалгаруулах” тэмцээнээс нийт 25 медальтан төрж, “Зэвсэгт хүчний аварга” хэмээх алдрыг хүртэх гэнэ.

“Аватар” киноны 2-5 дугаар ангийн зохиол бэлэн болжээ

Н.БОЛД

Алдарт найруулагч Жемис Камерон “Аватар” киногоо дэлгэцэнд гаргаж, дэлхий нийтийг байлдан дагуулснаас хойш долоон жил өнгөрч байгаа билээ. Энэ кино гарснаас хойш удаах ангиудыг нь хийх талаар ярьж эхэлсэн. Тэгвэл Жемис Камерон саяхан өгсөн ярилцлагынхаа үеэр “Аватар” киноны үргэлжлэл болох 2-5 дугаар ангийн зохиолыг бүрэн бичиж дуусгасан гэдгээ мэдэгджээ. Улмаар энэ оны наймдугаар сараас жүжигчидтэйгээ зураг авалтаа хийж эхлэх юм байна. “Аватар”-ын удаах анги буюу “Аватар-2” 2018 оны арванхоёрдугаар сард дэлгэцнээ гарах бол гуравдугаар анги нь 2020, дөрөв нь 2022, тавдугаар анги нь 2023 онд нээлтээ хийх аж.

Бидэнд тохиолдсон

Солонго Бука Соко

Манай хүүгийн сургуульд болсон явдал. Боловсролын яамнаас сургуульд нь шалгалт ирээд сургуулийн эмч, эрхлэгч, захирал, яамныхан ангиудаар явж л дээ. Өмнөх долоо хоногт нь дархлаажуулалтын аян гээд эмчтэйгээ цуг витамин тараасан юм билээ. Тэгээд нэгдүгээр ангийнхан дээр ороод захирал “Намайг таниж байна уу” гэхэд нь хүүхдүүд “Таниж байна” гэж хариулж байх юм гэнэ. Хариуд нь захирал “Хэн билээ” гэж асуужээ. Хүүхдүүд ч “Сургуулийн захирал” гээд л хариултал эмчийг заагаад “Энэ хүнийг таних уу” л гэж байна гэнэ. Бүгд танинаа л гэж хариулж. Захирал хэн билээ гэсэнд ангийхан “Витамин зардаг эмээ” гэжүү хэ хэ хэ.